



# **БАРУУН ГАР ТАЛДАА ЖОЛООНЫ ХҮРДТЭЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭД АНГИЙГ ҮНДЭСНИЙ СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН СОЛЬЖ ӨӨРЧЛӨХ ТАЛААРХ СУДАЛГАА**

**Захиалагч: Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ**

**Гүйцэтгэгч: Эм Ай Си Жи ХХК**

**2022 ОН**

## АГУУЛГА

<b>1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ</b> .....	8
1.1 Хууль, эрх зүйн орчны судалгаа .....	8
1.2 Зам тээврийн ослын судалгаа .....	17
1.3 Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн зам, тээврийн осол, зөрчлийн шинжилгээ .....	22
1.4 Бүлгийн дүгнэлт .....	27
<b>2 ГАДААД ОРНЫ ТЭРГҮҮН ТУРШЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ</b> .....	30
2.1 Гадаад орны тэргүүн туршлага .....	30
2.2 Бүлгийн дүгнэлт .....	48
<b>3 ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГАА</b> .....	51
3.1 Жолооны системийн эд ангийн байрлалыг өөрчлөх .....	52
3.2 Хяналтын самбар, түүнд байрлах хэрэгслийг өөрчлөн шинэчлэх 53	
3.3 Их гэрлийн тусгалыг өөрчлөн тохируулах.....	53
3.4 Тоормосны системийн эд ангийн байрлалыг шилжүүлэх .....	59
3.5 Хажуугийн толины тохируулгыг өөрчлөх, шинэчлэх.....	61
3.6 Эдийн засгийн тооцоолол .....	61
3.7 Бүлгийн дүгнэлт .....	67
<b>4 САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b> .....	69
Ном зүйн жагсаалт.....	72
<b>ХАВСРАЛТ</b> .....	73
4.1 Тээврийн хэрэгсэл, автомашины тоо.....	73
4.2 Авто тээврийн салбарын дүрэм, журмууд.....	74

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1 Авто зам, авто тээврийн эрх зүйн актууд .....	11
Хүснэгт 1-2 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, сар бүрээр.....	20
Хүснэгт 1-3 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, өдөр, шөнийн цагаар .....	21
Хүснэгт 1-4 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, ослын үр дүн, Улаанбаатар-Орон нутгаар.....	22
Хүснэгт 1-5 Авто тээврийн осол, осолд эзлэх баруун гар талдаа жолоотой автомашины эзлэх хувь.....	23
Хүснэгт 1-6 Автомашины жолооны хүрдний байрлал .....	25
Хүснэгт 1-7 Жолооны хүрднээс шалтгаалах осол болон үүссэн хэргийн бүртгэл.....	27
Хүснэгт 1-8 Жолооны хүрдтэй холбоотой ослын шалтгаан ба хүрдний байрлал.....	27
Хүснэгт 3-1 Тоёота Нарриер автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон өөрчлөхөд шаардлагатай сэлбэгийн өртөг.....	65
Хүснэгт 3-2 Тоёота Нарриер автомашины сэлбэгийн үнэ, зураг.....	66
Хүснэгт 3-3 Тоёота Нарриер автомашины нийт зардлын тооцоо .....	67

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины эзлэх хувь, осолд эзлэх хувь, тэдгээрийн зөрүү.....	23
Зураг 1-2. Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын шалтгаан .....	24
Зураг 1-3. Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины эзлэх хувь болон осолд эзлэх хувийн харилцан хамаарал.....	26
Зураг 3-1 Ойрын гэрлийн тусгал (тэгш бус хэмт) .....	54
Зураг 3-2 Холын гэрлийн тусгал (тэгш хэмт) .....	54
Зураг 3-3 Бэлдэц суурилуулсан байдал.....	55
Зураг 3-4 Наах цэгийг тодорхойлох цаас болон линз.....	56
Зураг 3-5 Их гэрлийн гадаргууд линзийг наасан байдал.....	57
Зураг 3-6 H4 маркийн лампад нэмэлт хаалт хийсэн байдал .....	58
Зураг 3-7 Тоёота Харриер автомашины үнэ .....	64
Зураг 3-8 Lexus RX автомашины үнэ .....	65

## ТОВЧИЛСОН ҮГС

Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл – RHD

Зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл – LHD

УДИРТГАЛ





## УДИРТГАЛ

Манай автомашин эзэмшигчид Япон, Австрали, Гонконг зэрэг улсаас зүүн гарын дүрмийн дагуу Япон, Герман, АНУ, Солонгос зэрэг улсад үйлдвэрлэгдсэн автомашиныг олноор импортлон хэрэглэж байна. Энэхүү автомашинууд нь ашиглалтын найдвартай байдал, эдэлгээний чанар, тохь тух, эдийн засгийн хэмнэлт, шатахууны зарцуулалт бага зэрэг чанараараа хэрэглэгчийн таашаалд ихээхэн нийцдэг. Ингэснээр Улаанбаатар хот болон бусад суурин газарт унаж ашиглаж байгаа суудлын автомашины 66%-ийг баруун талдаа жолооны хүрдтэй автомашин эзлэх болсон.

Эдгээр автомашин нь зүүн гарын дүрмээр үйлдвэрлэгдсэн байдлаасаа шалтгаалан дараах хүндрэлүүд бий болдог. Үүнд:

1. Шөнийн цагаар их гэрлийн ойрын гэрэлтүүлэг нь өөдөөс явж байгаа тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчийн нүдийг гэрлийн гялбаанд оруулах,
2. Жолооч баруун гар талдаа байрлан суудаг учир урдаа яваа том оврын тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхийн тулд автомашины ихэнх хэсэг зүүн гар тал руу шилжиж, цухуйсны дараа өөдөөс ирж байгаа тээврийн хэрэгслийг харах боломжтой болдгоос болж осолтой, хүндрэлтэй байдал бий болдог. Энэ нь сөрөг хөдөлгөөнтэй хоёр эгнээ орон нутгийн замд илүү аюултай байдал байдаг.
3. Урд суудалд суугаа зорчигч бууж, суухдаа зорчих хэсэгт байрлах шаардлагатай болдог.

Хөдөө орон нутагт хатуу хучилттай замд гүйцэж түрүүлэх үедээ эсрэг урсгалд орж мөргөлдөж, шүргэлцсэн, шөнийн цагаар гэрлийн гялбаанд орж осол гарсан тохиолдол цөөнгүй байна<sup>1</sup>. Мөн баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслээс шалтгаалж байгааг судалгааны хэсэгт дэлгэрэнгүй дурдсан.

Сүүлийн жилүүдэд баруун талдаа жолооны хүрдтэй автомашиныг импортлохыг хориглох, автомашиныг баруун гарын дүрэмд нийцүүлэн жолооны хүрдний байрлалыг өөрчлөх асуудлыг Монгол улсын засгийн газар, төр захиргааны байгууллагын хэмжээнд хэлэлцэж, судалж байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй

---

<sup>1</sup> Дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү.

байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн маш зөв алхам юм.

Төр засгийн зүгээс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний нэг болох зүүн гарын дүрмээр үйлдвэрлэгдсэн автомашины жолооны хүрдийг шилжүүлэн байрлуулах боломжийн талаар судалж байгаа нь цаг үеэ олсон маш чухал асуудал болоод байна.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**

Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байрлалыг өөрчлөн зүүн талд шилжүүлэх боломжийн талаар судлан, санал дүгнэлт боловсруулах.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛТ**

- Баруун гарын хөдөлгөөнийг баримталдаг замын хөдөлгөөнд баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслээр оролцоход учирдаг осолтой тохироо, бэрхшээлийг илрүүлэх, дүгнэх,
- Тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг шилжүүлэн байрлуулж буй гадаад орны туршлага, эрх зүйн орчин, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг судлах,
- Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн талд шилжүүлэх техникийн шийдэл, технологи, зардлыг тодорхойлох,
- Тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг шилжүүлэн байрлуулах аргачлал, санал зөвлөмж боловсруулах.

## **СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ**

- Монгол улсад замын хөдөлгөөний баруун гарын дүрмийг баримталдаг. Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашин нь зүүн гарын дүрмээр зорчиход зориулан үйлдвэрлэгдсэн байх тул зарим талаараа нийцэхгүй байна.
- Зүүн гарын дүрмээр зорчиход зориулан үйлдвэрлэгдсэн автомашиныг жолоодон баруун гарын дүрмийн дагуу замын хөдөлгөөнд оролцоход жолооч болон зорчигчид осолтой, бэрхшээлтэй байдал бий болдог.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН,  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ



## 1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

---

### 1.1 Хууль, эрх зүйн орчны судалгаа

Монгол Улсын Засгийн газар “Авто тээврийн тухай хууль”-ийн төслийг боловсруулан 1999 оны 06 сарын 04-ны өдрийн УИХ-ийн хуралдаанаар хэлэлцэн баталсан нь авто тээврийн салбарын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, төрийн бодлогыг тодорхойлох ач холбогдолтой үйл явдал болсон байна.

Энэ хуулийн зорилт нь авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон авто тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, авто тээвэрлэлт болон авто тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-иар (1999.04.30) замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зарчим, техникийн аюулгүй байдлын шаардлагыг тусгасан. /2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр шинэчлэгдсэн/

1968 оны 11 дүгээр сарын 08-ны Вена хотноо зохион байгуулагдсан “Замын хөдөлгөөний тухай конвенц”, “Замын дохио, тэмдгийн тухай конвенци” –ийг тус тус хүлээн зөвшөөрч манай улс 1997 оны 07 сарын 09-ний өдөр нэгдэн орсон.

“Авто тээврийн тухай хууль” -ийн 4-р бүлгийн 18 дугаар зүйлийн 18.1. -т Авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. /Энэ хэсгийг 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-ийн 5-р бүлгийн 21 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл, түүний хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, импортлоход тавих шаардлага”-ын:

- 21.1.-т Монгол улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор тус улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл, түүний



хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинжлэх ухааны холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байна.

- 21.2.-т Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна.
- 21.3.-т Гадаад улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.
- 21.4.-т Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно.
- 21.5.-д Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн хийцийг өөрчилсөн тохиолдолд техникийн хяналтын үзлэг, оношилгоог давтан хийлгэж гэрчилгээ авна. гэж тус тус заасан байна.

Зам, тээвэр хөгжлийн сайдын 2018 оны “Улсын үзлэг явуулах тухай” 146 дугаар тушаалаар зохион байгуулагдсан “Авто тээврийн салбар”-ын стандартын улсын үзлэгээр нийт 112 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нь тогтоогдсон. Тус салбарт мөрдөгдөж буй 112 стандартын эрхзүйн байдлыг харвал “Сонгон хэрэглэх” 60, “Заавал мөрдөх 52 стандарт байна.

### Хүснэгт. Авто тээврийн салбарын стандарт

№	Стандартын тоо	Үндэсний стандартын төрөл				Эрхзүйн байдал	
		Бүтээгдэхүүний	Шинжилгээний арга, аргачлалын	Нэр томьёо	Бусад	Заавар мөрдөх	Сонгон хэрэглэх
1	112	4	27	21	60	52	60

Эх сурвалж: Стандартын улсын үзлэг, 2018 он

Эдгээрээс олон улсын стандарт ( ISO) 48, бүс нутгийн буюу европын холбооны (EN) 3, гадаад орны (ASTM) 1, Монгол улсын үндэсний стандарт (MNS) 60 байх ба нийт стандартын 54% нь үндэсний 46% нь олон улсын стандарт байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Европын Эдийн засгийн комисс (ЕЭК)-оос гаргасан 2010 оны 8 сарын 31-ны өдрийн судалгаанд бүртгэгдсэн 57 гэрээ, хэлэлцээрээс авто тээврийн салбарын дараах 4 конвенцод нэгдэн орсон байна. Үүнд:

1. Замын хөдөлгөөний тухай Конвенц (Вена 1968)
2. Замын дохио, тэмдгийн тухай Конвенц (Вена 1968)
3. ТИР Карнейг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц (1975 он)
4. Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц (1982 он) 1997 оны эхээр Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Европын Эдийн засгийн комисс (ЕЭК)-оос гаргасан судалгаагаар 2011 онд нэгтгэсэн “Хууль эрх зүйн акт, гэрээ хэлэлцээр, норм болон стандартын жагсаалт” - д тээврийн салбарын 57 олон улсын гэрээ, хэлэлцээр бүртгэгдсэн байдаг байна.

Авто тээврийн салбарын олон улсын гэрээ, хэлэлцээр

Д/д	НҮБ-д бүртгэгдсэн авто салбарын гэрээ, хэлэлцээр, конвенцын ангилал	НҮБ-д бүртгэгдсэн гэрээ, хэлэлцээр, конвенцын тоо	Монгол улсын нэгдэн орсон гэрээ, хэлэлцээр
1	Тээврийн дэд бүтэц	6	
2	Замын хөдөлгөөн ба дохио тэмдгийн тухай	11	2
3	Механикжсан тээврийн хэрэгсэл ба чиргүүл	3	
4	Авто замын тээвэрлэлттэй холбоотой бусад гэрээ хэлэлцээр	Ажиллах нөхцөл	1
		Албан татвартай холбоотой	3
		Хувийн эрхзүй	5
		Эдийн засгийн зохицуулалт	1
5	Дотоодын усан замын тээвэрлэлт	8	
6	Хилийн бүсийн хөнгөлөлт	14	2
7	Аюултай ачааны тээвэрлэлт	4	
8	Хүнсний түргэн мууддаг, эмзэг бүтээгдэхүүний тээвэрлэлт	1	
	Нийт	57	4

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй авто тээврийн салбартай холбоотой үндсэн хэм хэмжээ болсон дараах эрх зүйн актууд байна.

#### Хүснэгт 1-1 Авто зам, авто тээврийн эрх зүйн актууд

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо
1	Авто тээврийн тухай хууль	1999-06-04
2	Авто замын тухай /шинэчилсэн найруулга/	2017-05-11
3	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2015-07-08
4	Замын дохио, тэмдгийн тухай Конвенц <sup>2</sup>	1997-07-09
5	Замын хөдөлгөөний тухай Конвенц <sup>3</sup>	1997-07-09
6	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм	Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоол

<sup>2</sup> 1968 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Вена хотноо байгуулсан "Замын дохио, тэмдгийн тухай Конвенц"-ийг Монгол Улс 1997 оны 7 дугаар сарын 09-ний өдөр хуулиар нэгдэн орж, соёрхон баталсан байдаг.

<sup>3</sup> 1968 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Вена хотноо байгуулсан "Замын хөдөлгөөний тухай Конвенц"-ийг Монгол Улс 1997 оны 7 дугаар сарын 09-ний өдөр хуулиар нэгдэн орж, соёрхон баталсан байдаг.

7	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/199 дүгээр тогтоол
---	---	---

Дээрх эрх зүйн хэм хэмжээ нь судлан буй сэдвийн хүрээнд шууд хамааралтайгаар үйлчлэх зохицуулалт болно. Судлан буй сэдэвт шууд хамааралтай дээрх хууль тогтоомжуудад баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг үндэсний стандартад буюу зүүн гар талд шилжүүлэхээр дэлгэрэнгүй байдлаар шууд заасан томъёолол бүхий зохицуулалтгүй байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4 дэх хэсэгт тус тус зааснаар нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах зүй ёсны шаардлага үүсэж байна. Судлан буй асуудлыг нэн тэргүүнд хуулиар зохицуулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан дөрвөн нөхцөл байдал үүсэхгүй тул судлаачийн зүгээс хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8.1.3-т “*байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээ, үндэсний тээвэр логистикийн тогтолцоог хөгжүүлнэ*” хэмээн тодорхойлсон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтод тухайн асуудлыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн арга хэмжээ нь нийцэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын иргэн бүр хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй байхаар, тэрхүү эрхийг нь хуулиар хамгаалахаар зохицуулсан байдаг. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх хэдий ч хуульд зааснаар хөдлөх эд хөрөнгө<sup>4</sup>-д хамаардаг. Тухайн судлан буй асуудлыг нийгэмд гаргаж тавихад хамгийн ихээр хүндрэл үүсэж болзошгүй эрсдэл нь иргэний өмчлөх эрхэд төр хөндлөнгөөс хязгаарлалт тавих гэсэн агуулгаар

<sup>4</sup> Монгол Улсын Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 дэх хэсэг.



тайлбарлагдана. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт зааснаар иргэд улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхтэй. Уг эрхийн зөрчил шууд бус хамаарлаар илрэх магадлалтай буюу хэрэв баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг үндэсний стандартад нийцүүлэн жолооны хүрдийг зүүнд шилжүүлэхэд өмчлөх эрхийг хууль ёсны дагуу хязгаарлах шаардлага үүснэ.

Хуульд зааснаар өмчлөгчийн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлана. Тухайн судлан буй сэдвийн агуулга нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолооч, зорчигчийн амь нас эрсдэх, эрүүл мэндэд хохирол учрах зэрэг сөрөг нөхцөл байдлаас хамгаалах үндсэн чиглэлтэй. Тодруулбал, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан<sup>5</sup>-д байршсанаар 2018-2021 онуудад улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн Тусгай 27.10 дугаар зүйлд заасан “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” гэмт хэрэгт холбогдох хэргийн статистик мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар авч үзвэл тухайн төрлийн гэмт хэргийн гаралт болгоомжгүй гэм буруугийн хэлбэртэйгээр үйлдэгдсэн ч нийт гарсан гэмт хэргийн статистикт өндөр үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 1-2 Эрүүгийн гэмт хэргийн статистик мэдээлэл /улсын хэмжээнд/

№	Хохирол, хор уршиг	Хуулийн зүйл заалт	2018	2019	2020	2021	Арифметик дундаж
1	Хүндэвтэр гэмтэл учруулсан	Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	412	452	327	277	367.0
2	Хүнд гэмтэл учруулсан	Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2.3 дахь заалт	261	268	188	188	226.25
3	Хүний амь нас хохирсон	Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	167	168	154	144	158.25
4	2 болон түүнээс дээш хүний амь нас хохирсон	Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 4.2 дахь заалт	27	20	7	15	17.25

<sup>5</sup> [www.shuukh.mn](http://www.shuukh.mn)

5	Их хэмжээний хохирол <sup>6</sup> учруулж үйлдсэн	Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 2.4 дэх заалт	6	6	9	12	8.25
---	---	---	---	---	---	----	------

Дээрх хүснэгтээс авч үзвэл улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь тухайн онд гарсан нийт гэмт хэрэгт эзлэх хувь, жин өндөр байдаг. Тодруулбал, 2018 онд шүүхээр шийдвэрлүүлсэн 12349 гэмт хэргийн 7 хувь, 2019 онд шүүхээр шийдвэрлүүлсэн 13431 гэмт хэргийн 6.8 хувь, 2020 онд шүүхээр шийдвэрлүүлсэн 13354 гэмт хэргийн 5.1 хувь, 2021 онд шүүхээр шийдвэрлүүлсэн 11946 гэмт хэргийн 5.3 хувийг эзэлж байна. Энэ нь зөвхөн бусдын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийн шинжтэй гэж анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн эзлэх хувь болно.

Түүнчлэн Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтаар суудлын автомашинд онцгой албан татвар ногдохоор хуульчлагдсан. Ингэхдээ биет нэгжээр тооцож, ширхэг тутамд татвар ногдуулдаг<sup>7</sup>. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт зааснаар “суудлын автомашин импортолсон бол үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан...” ялгамжтай байдлаар онцгой албан татвар ногдуулдаг. Харин жолооны хүрдний байршлыг харгалзан татварыг ялгамжтай ногдуулах зохицуулалт байхгүй байна.

Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг<sup>8</sup>-т заасан татвараас чөлөөлөх дөрвөн нөхцөл, мөн онцгой албан татвараас хөнгөлөх

---

<sup>6</sup> Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.4-т "их хэмжээний хохирол" гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгохоор хуульчилсан буюу 50,000,000 төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учирсан байхыг ойлгоно.

<sup>7</sup> Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг.

<sup>8</sup> 1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэн экспортод гаргасан энэ хуулийн 4.1-д заасан бараа;  
2. гэрийн нөхцөлд энгийн аргаар өөрийн хэрэгцээнд зориулж сүү, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи;  
3. хамрын тамхи;

зохицуулалтыг 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар “Хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлнө” гэсэн зохицуулалтыг хүчингүй болгосон байдаг.

Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй авто тээврийн хэрэгслийг /байлдааны тусгай зориулалттайгаас бусад/ замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно” гэж, 17.4 дэх хэсэгт “Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг техникийн оношилгоонд оруулж, стандартын шаардлага хангуулсны дараа улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгоно” гэж тус тус заасан байдаг. Тодруулбал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/199 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам”-д зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгсэл, мотоцикл, механизм хамаардаг. Журам нь тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал буюу замын хөдөлгөөнд оролцох шаардлага хангасан эсэхээр тодорхойлогддог. Харин тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлаас хамааруулан техникийн хяналтын үзлэг хийж, хөдөлгөөнд оролцох эсэхийг шийдвэрлэх зохицуулалтгүй буюу зохицуулах харилцаанд нь хамаарахгүй байна.

Мөн журмын 2.7-д зааснаар тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахгүй байхаар заасан байна.

Тодруулбал, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэгт тус тус зааснаар тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр даатгалд заавал даатгуулах ёстой ба даатгуулаагүй тохиолдолд **тээврийн хэрэгслийг ашиглан замын хөдөлгөөнд оролцох**, тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг хориглосон байна.

---

4. гаалийн байгууллагаас зорчигчдын хувийн хэрэгцээнд зориулж татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээний архи, тамхи;

Өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд дээр дурдсан эрх зүйн хэм хэмжээнд зааснаас бусад тохиолдолд тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хязгаарлах, хориглох зохицуулалт байхгүй байна. Тодруулбал, судлан буй сэдвийн хүрээнд буюу баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй, хориглох, хязгаарлах зэргээр императив<sup>9</sup> шинжтэй зохицуулалт байхгүй, татварын хууль тогтоомжид жолооны хүрдний байршлыг харгалзан онцгой албан татварыг өөрөөр тогтоох эрх зүйн орчин байхгүй байна.

Иймд судлан буй асуудлын хувьд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн шаардлага зүй ёсоор үүсэхээр байна. Ингэхдээ дагалдан гарах хууль тогтоомжийн төсөл болон дагаж мөрдөх журмын тухай хуулиар шилжилтийн үеийн зохицуулалтаар хууль батлагдахын өмнө орж ирсэн ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийн өмчлөгчийн өмчлөх эрхийг хөндөхгүй байхаар тусгах боломжтой. Харин судлан буй асуудлын нарийвчилсан зохицуулалтыг Захиргааны хэм хэмжээний актад тусгах нь Хууль тогтоомжийн тухай хууль болон хууль зүйн техник талаасаа оновчтой хувилбар болох тул Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Захиргааны хэм хэмжээний акт батлах эрхийг зам, тээврийн хөгжлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлахаар тусгах шаардлагатай гэж үзэж байна.

---

<sup>9</sup> Хориглосон, хязгаарласан шинжтэй эрх зүйн хэм хэмжээг ойлгоно.



## 1.2 Олон улс

Олон Улсын хамтын ажиллагаа нэн хурдацтай хөгжихийн хэрээр улс хоорондын ачаа тээвэрлэлтийн зохион байгуулалт, олон улсын замын хөдөлгөөний аюулгүй, шуурхай, оновчтой байдлыг нэгдмэл хүрээнд хангах асуудлыг улам бүр нарийвчлан тогтоох зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Эдгээр шаардлагыг хангах үүднээс Олон Улсын авто тээврийн харилцааны эрх зүйн салбарт Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын ивээл дор байгуулагдсан Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүдийн бүхэл бүтэн систем бүрэлдэн тогтжээ.

Нэгдсэн үндэстний байгууллагын Европын эдийн засгийн комиссоос 2011 онд судлагдсан байдлаар “Хууль эрх зүйн акт, гэрээ хэлэлцээр, норм болон стандартын жагсаалт”-д Механикжсан тээврийн хэрэгсэл ба чиргүүл ангилалд авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын талаар нэгдмэл нөхцөл бүрдүүлэх тухай дор дурдсан 3 гэрээ, хэлэлцээр бүртгэгдсэн. Үүнд:


1. “Тээврийн хэрэгсэл түүний эд анги ба тоног төхөөрөмжийн нэгдсэн зааварчилгааны гэрээ ба харилцан хүлээн зөвшөөрөл” -1958 он.
2. “Тээврийн хэрэгслийн олон улсын техникийн зохицуулалтын гэрээ” -1998 он.
3. “Тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг тогтмол явуулах нэгдмэл нөхцөл бүрдүүлэх ба уг үзлэгийг харилцан хүлээн зөвшөөрөх” тухай -1997 он.

Эдгээр гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон орнууд Олон Улсад Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтын харилцан хүлээн зөвшөөрөх дэлхийн форум (WP.29)-д нэгдэн тээврийн хэрэгслийн эд анги, тоног төхөөрөмжийн стандартыг харилцан хүлээн зөвшөөрч ажиллаж байна.

НҮБ-ийн Европын эдийн засгийн комиссын Дотоодын тээврийн хороо (UNECE-WP.29)-ийн Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын стандартыг бий болгох 6 ажлын хэсэг ажиллаж жилд 6 удаа Олон Улсын хурал /Дэлхийн форум/ зохион байгуулагддаг.


Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх дэлхийн форум (WP.29)-ын бүтэц зохион байгуулалтыг зураг 8-д харуулав.

Зураг 8. Дэлхийн форум зохион байгуулалт, бүтэц



Дор дурдсан гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон орнууд Олон Улсад Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтын харилцан хүлээн зөвшөөрөх дэлхийн форум (WP.29)-д нэгдэн тээврийн хэрэгслийн эд анги, тоног төхөөрөмжийг харилцан хүлээн зөвшөөрч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын стандартыг бий болгох, сайжруулах зорилгоор ажилладаг байна.

Зураг 9. WP.29 Олон улсын хэлэлцээр



“Тээврийн хэрэгсэл түүний эд анги ба тоног төхөөрөмжийн нэгдсэн зааварчилгааны гэрээ ба харилцан хүлээн зөвшөөрөл” 1958 оны гэрээнд Авто тээврийн хэрэгсэл түүний эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн тус бүрд

тавигдах шаардлагыг тусгасан 127 техникийн зохицуулалт, стандарт байдаг.

1958 оны гэрээнд нэгдэн орсон орнууд эдгээр 127 техникийн зохицуулалт, стандартыг харилцан хүлээн зөвшөөрч эдгээрээс сонгон хэрэглэж, үндэсний хууль тогтоомж эрх зүйн баримт бичигтээ нийцүүлэн дагаж мөрдөж байна. Жишээлбэл:

БНСУ-д 23 техникийн зохицуулалтыг харилцан хүлээн зөвшөөрч ажиллаж байна. Мөн Ази номхон далайн бүс нутгийн тээврийн хэрэгслийн стандартын зохицуулалтын дэд хороо нь тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаа, утаа ялгаруулалтын талаарх хууль, дүрмийн зохицуулалтыг олон улсын холбогдох стандарт, шаардлагууд болон АПЕК дэх автомашин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтыг зохицуулах, уялдуулах үндсэн үүрэгтэй. Мөн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг хөгжүүлэх UNECE Regulations and Global Technical Regulations (GTR)-тэй тухайн улсын дотоодын авто тээврийн хуулийн зохицуулалтын асуудлаар хамтран ажиллах үүрэгтэй. VSHG нь дүрэм журмын зохицуулалтыг дэмжих, гэрчилгээжүүлэлт, зохицуулалтын системийг хөгжүүлэхэд туслах үүрэгтэй. Мөн 1958 болон 1998 оны гэрээнүүдэд тусгагдсан заалт, ойлголтуудын талаарх мэдээллийг дамжуулах, түгээх зорилгоор форум зохион байгуулдаг.

Авто тээврийн хэрэгслийн ашиглалт аюулгүй байдалтай холбоотой эдгээр баримт бичгийг судлан үзэхэд Олон Улсад Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтын харилцан хүлээн зөвшөөрөх дэлхийн форум (WP.29)-д нэгдэн орсон улс орон нь тээврийн хэрэгслийн эд анги тоног төхөөрөмжийн стандарт, техникийн зохицуулалт, үндэсний хууль тогтоомжийг нэгдсэн байдлаар боловсруулан дагаж мөрдөж байна.

Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтын харилцан хүлээн зөвшөөрөх дэлхийн форум (WP.29)-д нэгдсэн орнууд автомашин түүний эд ангийн үйлдвэрлэл явуулах, үйлдвэрлэх бүтээгдэхүүний зураг төслийг зохион бүтээх, сорилт туршилт хийх, тохирлын гэрчилгээ олгох, худалдаанд гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг энэхүү хэлэлцээрийн хавсралт болох техникийн зохицуулалт, дүрэм, журамд нийцүүлэн үйлдвэрлэдэг байна.

Монгол улс НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын Дотоодын тээврийн хорооны Тээврийн хэрэгслийн техникийн зохицуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх Дэлхийн форум (UNECE WP29) –д нэгдэн дор дурдсан хэлэлцээрт

нэгдэн орох боломжийг судлан үзэж, холбогдох ажлыг зохион байгуулснаар автомашин түүний эд ангийн үйлдвэрлэл, ашиглалт, аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлэх, импорт, экспорт, дотоод худалдаатай холбоотой харилцааг зохицуулах, үйлдвэрийн сорилт туршилтыг чанартай хийх зэрэг ажлыг зохион байгуулах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой байна.

1. “Тээврийн хэрэгсэл түүний эд анги ба тоног төхөөрөмжийн нэгдсэн зааварчилгааны гэрээ ба харилцан хүлээн зөвшөөрөл” 1958 он.

2. “Тээврийн хэрэгслийн олон улсын техникийн зохицуулалтын гэрээ” 1998 он.

3. “Тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг тогтмол явуулах нэгдмэл нөхцөл бүрдүүлэх ба уг үзлэгийг харилцан хүлээн зөвшөөрөх” тухай. 1997 он.

### 1.3 Зам тээврийн ослын судалгаа

Тээврийн цагдаагийн албаны 2010 оноос хойших зам тээврийн ослын нийт бүртгэл мэдээллийг ашиглаж энэхүү судалгааны хэсгийг хийв. Судалгааны эхний хэсэг сүүлийн 12 жилийн байдлаар ослын тоог сараар харуулж байна. Ослын нийт тоогоор 6-9-р сарууд хамгийн өндөр байна. Энэ нь аялал зугаалгатай холбоотой ачаалал нэмэгддэгтэй холбоотой байна.

#### Хүснэгт 1-2 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, сар бүрээр<sup>10</sup>

ОН/САР	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
2010	95	120	129	115	146	177	184	186	218	209	178	128	1,885
2011	124	97	152	147	192	169	225	221	225	250	202	118	2,122
2012	128	136	168	172	222	200	189	211	241	228	181	155	2,231
2013	117	139	180	152	222	219	220	221	235	271	193	164	2,333
2014	145	160	155	171	201	203	214	264	241	270	220	184	2,428
2015	183	191	198	182	201	224	221	231	171	219	146	157	2,324
2016	101	139	159	157	207	207	178	203	197	195	130	102	1,975
2017	121	111	147	131	154	153	237	203	222	200	134	175	1,988
2018	125	134	168	198	204	200	211	221	200	200	178	171	2,210
2019	147	156	224	211	258	262	240	246	235	216	181	169	2,545
2020	142	146	93	86	125	144	137	142	131	164	62	65	1,437
2021	63	47	80	50	85	102	135	127	134	159	120	170	1,272
2022	89	98	128	125	144	160	168	65	3				980
<b>Нийт</b>	<b>1,580</b>	<b>1,674</b>	<b>1,981</b>	<b>1,897</b>	<b>2,361</b>	<b>2,420</b>	<b>2,559</b>	<b>2,541</b>	<b>2,453</b>	<b>2,581</b>	<b>1,925</b>	<b>1,758</b>	<b>25,730</b>

<sup>10</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба



Зам тээврийн ослыг Өдрийн цаг, Шөнийн цагаар ялгааг дараах байдлаар харуулж байна. Сүүлийн 12 жилийн дунджаар шөнийн цагаар гарч байгаа ослын тоо өдрийн цагаар гарч буй ослоос 3.6 дахин их байна. Энэ нь шөнийн цагаар гүйцэд түрүүлэх, хурд хэтрүүлэх, гэрэл гялбах зэргээр үзэгдэх орчин муу байх нь осолд нөлөөлдөг болохыг харуулж байна.

### Хүснэгт 1-3 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, өдөр, шөнийн цагаар<sup>11</sup>

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
<b>Өдөр</b>	<b>1,179</b>	<b>1,264</b>	<b>1,457</b>	<b>1,397</b>	<b>1,685</b>	<b>1,694</b>	<b>1,750</b>	<b>1,777</b>	<b>1,774</b>	<b>1,873</b>	<b>1,419</b>	<b>1,307</b>	<b>18,576</b>
2010	62	81	83	78	89	119	106	122	147	146	120	74	1,227
2011	87	71	109	105	137	114	139	157	162	172	131	84	1,468
2012	85	106	121	129	150	137	119	160	166	150	141	104	1,568
2013	89	98	136	101	139	157	151	148	167	185	133	117	1,621
2014	105	126	104	134	144	144	158	182	175	187	169	130	1,758
2015	137	142	148	114	151	163	145	140	115	164	114	133	1,666
2016	82	104	118	112	138	132	121	144	130	150	101	79	1,411
2017	97	88	110	102	111	112	178	136	174	148	111	127	1,494
2018	100	111	123	151	160	145	161	163	145	158	126	141	1,684
2019	113	119	181	161	196	181	165	181	190	164	142	134	1,927
2020	111	108	70	66	89	101	96	110	99	120	45	52	1,067
2021	43	37	53	48	68	76	100	91	101	129	86	132	964
2022	68	73	101	96	113	113	111	43	3				721
<b>Шөнө</b>	<b>401</b>	<b>410</b>	<b>524</b>	<b>500</b>	<b>676</b>	<b>726</b>	<b>809</b>	<b>764</b>	<b>679</b>	<b>708</b>	<b>506</b>	<b>451</b>	<b>7,154</b>
2010	33	39	46	37	57	58	78	64	71	63	58	54	658
2011	37	26	43	42	55	55	86	64	63	78	71	34	654
2012	43	30	47	43	72	63	70	51	75	78	40	51	663
2013	28	41	44	51	83	62	69	73	68	86	60	47	712
2014	40	34	51	37	57	59	56	82	66	83	51	54	670
2015	46	49	50	68	50	61	76	91	56	55	32	24	658
2016	19	35	41	45	69	75	57	59	67	45	29	23	564
2017	24	23	37	29	43	41	59	67	48	52	23	48	494
2018	25	23	45	47	44	55	50	58	55	42	52	30	526
2019	34	37	43	50	62	81	75	65	45	52	39	35	618
2020	31	38	23	20	36	43	41	32	32	44	17	13	370
2021	20	10	27	2	17	26	35	36	33	30	34	38	308
2022	21	25	27	29	31	47	57	22					259
<b>Нийт</b>	<b>1,580</b>	<b>1,674</b>	<b>1,981</b>	<b>1,897</b>	<b>2,361</b>	<b>2,420</b>	<b>2,559</b>	<b>2,541</b>	<b>2,453</b>	<b>2,581</b>	<b>1,925</b>	<b>1,758</b>	<b>25,730</b>

Одоо ослын тохиолдол бүрийг нягтлан шалгаж авч үзье. Үүний тулд Орон нутгийн зам, Улаанбаатар хотод гарсан осол гэж ангилсан. Үр дүнд сүүлийн 12 жилийн дунджаар Улаанбаатар хотын нийт ослын 82% нь мөргөж, онхолдсон осол 3%, хүн нас барсан осол 1%-ийг бүрдүүлж байна. Харин орон нутгийн замд гарсан нийт ослын 32% нь мөргөж, 22% онхолдсон, 9% нь хүн нас барсан, 7% нь хүн гэмтсэн ослууд тус тус эзэлж байна.

<sup>11</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба

## Хүснэгт 1-4 Зам тээврийн ослын тоо, 2010-2022 он, ослын үр дүн, Улаанбаатар-Орон нутгаар<sup>12</sup>

Ослын тохиолдол	Мөргөж	Онхолдсон	Хүн нас барсан	Хүн гэмтсэн	Хүн дайрсан	Машин мөргөсөн	Хүн мөргүүлсэн	Машинд мөргүүлсэн	Мотоциклоос унаж	Хөнгөн гэмтэл	Нийт
<b>Орон нутаг</b>	<b>3,961</b>	<b>2,717</b>	<b>1,154</b>	<b>885</b>	<b>498</b>	<b>201</b>	<b>186</b>	<b>158</b>	<b>99</b>	<b>43</b>	<b>12,262</b>
2010	189	142	109	88	53	11	7	2	4	9	796
2011	256	197	117	75	48	26	6	7	16	4	966
2012	263	182	103	86	57	26	11	14	4	6	1,019
2013	305	213	115	68	47	31	7	12	6	6	1,040
2014	344	259	109	86	62	37	20	14	16	4	1,210
2015	295	207	122	77	33	26	8	20	5	5	1,052
2016	305	188	84	57	37	17	13	14	3	4	913
2017	340	202	78	81	39	17	22	18	13	2	1,012
2018	413	279	90	74	19	1	36	10	9	1	1,111
2019	434	324	109	85	25	5	25	14	15	1	1,209
2020	312	226	53	40	37	1	16	10	3		776
2021	291	166	39	35	27	2	13	17	2	1	666
2022	214	132	26	33	14	1	2	6	3		492
<b>Улаанбаатар</b>	<b>10,889</b>	<b>385</b>	<b>150</b>	<b>46</b>	<b>153</b>	<b>398</b>	<b>152</b>	<b>184</b>		<b>14</b>	<b>13,291</b>
2010	769	21	25	3	34	86	66	17		7	1,089
2011	912	27	22	6	36	47	6	7		1	1,156
2012	971	29	16	7	23	48	5	9			1,209
2013	990	37	19		18	64	11	21		2	1,293
2014	994	34	18	4	6	36	12	15		1	1,218
2015	1,020	39	17	2	15	47	2	19			1,272
2016	846	35	9	2	9	42	7	25		1	1,062
2017	799	40	7	5	2	16	9	35		1	976
2018	978	41	4	10	3	3	9	9			1,099
2019	1,190	31	2	4	1	6	19	22			1,336
2020	583	23	3	3	1	2	3	4			661
2021	512	22	6		3	1	1	1		1	579
2022	325	6	2		2		2				341
<b>Нийт</b>	<b>14,991</b>	<b>3,108</b>	<b>1,307</b>	<b>941</b>	<b>651</b>	<b>599</b>	<b>343</b>	<b>342</b>	<b>99</b>	<b>57</b>	<b>25,730</b>

### 1.4 Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн зам, тээврийн осол, зөрчлийн шинжилгээ

Судалгааны энэхүү хэсэгт зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, баруун жолооны хүрднээс шалтгаалах нөлөөллийг тооцож судлах болно.

<sup>12</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба

2021 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн 22,482 зам тээврийн ослын 97.8% нь жолоочийн буруугаас, 2.1% нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 0.2% нь замын нөхцөлөөс шалтгаалсан гэж бүртгэгдсэн.

**Хүснэгт 1-5 Авто тээврийн осол, осолд эзлэх баруун гар талдаа жолоотой автомашины эзлэх хувь<sup>13</sup>**


Он	Зам тээврийн осол нийт	Үүнээс баруун гартаа жолооны хүрдтэй автомашин	Баруун гартаа жолооны хүрдтэй машины осолд эзлэх хувь	Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины хувь
2010	8,809	4,405	50%	48%
2011	19,440	10,109	52%	42%
2012	16,295	9,614	59%	49%
2013	18,367	14,662	50%	49%
2014	31,585	11,630	59%	52%
2015	45,161	41,064	64%	54%
2016	46,712	43,375	72%	56%
2017	36,591	26,346	72%	58%
2018	29,474	21,251	72%	61%
2019	25,302	18,470	73%	64%
2020	21,768	16,108	74%	65%
2021	22,482	16,862	75%	66%

Магадлалын онолоор баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины осолд өртөх тохиолдол автомашинд эзлэх хувьтай ойролцоо байх ёстой. 2010 онд ойролцоо буюу 2%, 2013 онд 1%-ийн зөрүүтэй байжээ. Гэвч баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины тоо өсөх тусам зөрүү нэмэгдэж 7-16% болсон байна. Импортоор орж ирэх баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины тоог хязгаарлах, татварыг нэмэгдүүлэх зэрэгт хориг тавивал энэхүү осол гэмтлийн тоо буурах боломжтой.

**Зураг 1-1. Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины эзлэх хувь, осолд эзлэх хувь, тэдгээрийн зөрүү**

<sup>13</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба


БАРУУН ГАР ТАЛДАА ЖОЛООНЫ ХҮРДТЭЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭД АНГИЙГ ҮНДЭСНИЙ СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН СОЛЬЖ ӨӨРЧЛӨХ ТАЛААРХ СУДАЛГАА



Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын шалтгааныг тоймлон авч үзвэл дараах байдалтай байна. Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын 26.6% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 28.2% нь анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, 18.5% нь хурд хэтрүүлснээс шалтгаалж, онхолдох хэлбэрээр 47.6% нь гарч хүний амь нас хохирчээ. Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хувь эдгээрээс Анхаарал болгоомжгүй оролцох, хурд хэтрүүлэх буюу нийт 47%-д тодорхой хэмжээгээр нөлөөтэй байна. Харин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон жолоочийн торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, жолооч дуудлагын үйлчилгээг албан ёсоор хуульчилж оруулах зэргээр чангаруулсан арга хэмжээ авах боломжтой байна.

**Зураг 1-2. Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын шалтгаан**





Монгол Улсад нийт 1,101,769 автомашин бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 75% буюу 826,327 автомашин баруун гар талдаа жолооны хүрдтэй байна. Энэ тоо 2010 онд 50% байсан бол жил бүр тогтмол өссөөр байна.

#### Хүснэгт 1-6 Автомашины жолооны хүрдний байрлал

Он	Автомашины тоо	RHD автомашин	RHD автомашины хувь
2010	254,486	122,153	48%
2011	312,542	131,268	42%
2012	504,423	247,167	49%
2013	620,661	304,124	49%
2014	674,869	350,932	52%
2015	720,766	389,214	54%
2016	766,019	428,971	56%
2017	815,009	472,705	58%
2018	871,350	531,524	61%
2019	934,510	598,086	64%
2020	1,004,800	653,120	65%
2021	1,101,769	727,168	66%


Судалгаанаас харахад Монгол Улсад ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн зохистой тоон харьцаа 2,3 дахин их байна. Цаашид нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ боломжуудыг судлах шаардлагатай байгааг харуулж байна.

ОХУ-ын судлаач В.Ю.Викулиний судалгаагаар 1000 тээврийн хэрэгсэлд ногдох Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 100 ширхэг болсон нөхцөлд

зам тээврийн ослын тоог 8%-аар өсгөх магадлалтай гэж тооцоолсон байдаг. Энэхүү үр дүнг манай улсын сүүлийн 12 жилийн баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины өсөлт, осол гэмтлийн өсөлт мөн баталж харуулж байна. Тиймээс баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашиныг 50%-иас ихгүй байлгах, цаашид үе шаттайгаар бууруулах шаардлагатай байна.

Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлаж автомашинд эзлэх хувь хэмжээг бууруулбал 2023 оноос 2031 оны хооронд эзлэх хувь хэмжээ дараах байдлаар буурахаар байна.

**Зураг 1-3. Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины эзлэх хувь болон осолд эзлэх хувийн харилцан хамаарал**



Тээврийн цагдаагийн албаны 2010 оноос 2022 оны дата мэдээллээс авто ослын тохиолдол бүрийг судлан жолооны хүрдний байрлалаар харьцуулан харуулж байна. Жолооч нь зугтсан, мэдэгдээгүй тохиолдолд машины марк байхгүй учраас Тодорхойгүй гэсэн ангилал үүсгэн авч үзлээ. Доорх хүснэгтэд жолооны хүрднээс шалтгаалж гарч болзошгүй ослын түүвэрлэн авахад хэрэг үүссэн байдал дараах байдалтай байна. Үр дүнгээс харахад баруун жолооны хүрдтэй авто машины осол нь дунджаар нийт ослын 78%-ийг эзэлж байна. Энэ нь зүүн хүрдтэй авто машинаас харьцангуй өндөр байгааг харуулж байна.

### Хүснэгт 1-7 Жолооны хүрднээс шалтгаалах осол болон үүссэн хэргийн бүртгэл<sup>14</sup>

Жолооны хүрд	Үүссэн хэрэг				Нийт
	Хөнгөн	Хүнд	Хүндэвтэр	Хэрэг үүсээгүй	
Баруун хүрдтэй	199	6	65	15	285
Зүүн хүрд	51	3	22	2	78
Тодорхойгүй	117	8	30	12	167
<b>Нийт</b>	<b>367</b>	<b>17</b>	<b>117</b>	<b>29</b>	<b>530</b>

Ослын шалтгааныг жолооны хүрдний байрлалтай нь харьцуулан авч үзлээ. Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу нийсэн нийт марк нь тодорхой 204 ослоос 155 нь баруун талдаа жолооны хүрдтэй буюу 76% нь байна. Энэ нь нийт авто машины баруун гар талдаа эзлэх хувь хэмжээ 66% байгаагаас өндөр үзүүлэлттэй байна.

Ослын шалтгаан бүрээр авч үзвэл Бараан гар талдаа жолооны хүрдтэй авто машин нь Зүүн гар талдаа жолооны хүрдтэй авто машинаас 2-4 дахин өндөр үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 1-8 Жолооны хүрдтэй холбоотой ослын шалтгаан ба хүрдний байрлал<sup>15</sup>

Ослын шалтгаанууд	Баруун хүрдтэй	Зүүн хүрд	Тодорхойгүй
Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	155	49	78
Зогсоох арга хэмжээ аваагүй	31	4	20
Анхаарал болгоомжгүй	19	4	23
Эсрэг урсгалд орсон	23	6	17
Эгнээ байр буруу эзэлсэн	10	5	6
Бусад холбоотой шалтгаан	44	14	32
<b>Нийт</b>	<b>282</b>	<b>82</b>	<b>176</b>

## 1.5 Бүлгийн дүгнэлт

Бүлгийн статистик мэдээлэл, түүнд хийсэн шинжилгээг нэгтгэн дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

- Магадлалын онолоор баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины осолд өртөх тохиолдол автомашинд эзлэх хувьтай ойролцоо байх ёстой. 2010 онд ойролцоо буюу 2%, 2013 онд 1%-ийн зөрүүтэй байжээ. Гэвч

<sup>14</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба

<sup>15</sup> Эх үүсвэр: Тээврийн цагдаагийн алба

баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины тоо өсөх тусам зөрүү нэмэгдэж 7-16% болсон байна.

- 2021 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн 22,482 зам тээврийн ослын 97.8% нь жолоочийн буруугаас болжээ. Мөн хүний амь нас хохирсон зам тээврийн ослын 26.6% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 28.2% нь анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, 18.5% нь хурд хэтрүүлснээс шалтгаалж, онхолдох хэлбэрээр 47.6% нь гарч хүний амь нас хохирчээ. Эндээс нэгтгэн дүгнэвэл тээврийн хэрэгслийн жолооны хүрднээс гадна жолоочийн хариуцлагатай байдал, зөв дадал хэвшлийг бий болгох, хуулийн чанга зохицуулалт нэн шаардлагатай байна. Үүнд:
  - Согтуугаар жолоо барьсан, хурд хэтрүүлсэн тохиолдолд торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх, эрхийг 1-3 жилээр хасах.
  - Дуудлагын жолоочийг үйлчилгээг хуульчлан оруулах. Дуудлагын жолоочийн үйлчилгээний нэгдсэн сүлжээг бий болгох, чадавхжуулахад анхаарах
  - Осол гэмтлийн статистик бүртгэл, мэдээллийг аймаг, дүүрэг бүр сар бүр онлайн хэлбэрээр олон нийтэд хүргэх.

Судалгааны ажилд тусгагдсан эрх зүйн хэм хэмжээнүүдийг судлан буй сэдвийн хүрээнд авч үзэж, үр дүнг нэгтгэн дүгнэвэл дор дурдсан нөхцөл байдал үүссэн болно.

Тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн талд шилжүүлэн зорчих хөдөлгөөний эсрэг талд гаргах эрх зүйн зохицуулалт бий болбол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын зам, тээврийн салбарын конвенцуудтай зөрчилдөхөөргүй байна.

Нэгэнт иргэдийн хэрэглээнд нэвтэрсэн баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг зүүн талд шилжүүлэх технологийг ашиглахад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай. Тодруулбал, Иргэдийн хувийн тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх хөндөгдөхөөр байна. Мөн тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчилж, түүнд хязгаарлалт тогтоовол Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан чөлөөтэй зорчих эрхийг хөндөх эрсдэл үүснэ. Иймд Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хүний болон иргэний үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлаж болохоор заасан тул Замын хөдөлгөөний аюулгүй

байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах хэрэгцээ зайлшгүй үүсэхээр байна.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон түүний харьяа байгууллагуудаас нэгдсэн зохион байгуулалт хийх үүднээс Захиргааны Ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан захиргааны хэм хэмжээний акт батлах бүрэн эрхийг хуулиар олгох шаардлагатай.

Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн эд ангийг үндэсний стандартад нийцүүлэн сольж өөрчлөх талаарх хууль, эрх зүйн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд импортоор оруулж ирсэн баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдийг зүүнд шилжүүлэх хугацаа, хяналт тавих төрийн захиргааны байгууллагад бүрэн эрхэд өөрчлөлт оруулах;

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Захиргааны Ерөнхий хуульд зааснаар жолооны хүрдийг өөрчлөхөд тавигдах шаардлага бүхий журам батлан мөрдүүлэх эрхийг Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэхээр тусгах;

## 2 ГАДААД ОРНЫ ТЭРГҮҮН ТУРШЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ

### 2.1 Гадаад орны тэргүүн туршлага

#### 2.1.1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛС

Үзүүлэлт	Дүн
Хүн амын тоо (2021 он)	212.7 сая
Газар нутгийн хэмжээ (км <sup>2</sup> )	8,515,767
Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо (2020 оны 12 сар)	1,412,206
Замын зорчих хэсэг дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл	Баруун

Бразил улс уг тоогоороо дэлхийн зургаа дахь хамгийн их хүн амтай орноор нэрлэгддэг. Цэргийн дарангуйлал 1964-1985 оны хооронд Бразил улсад тогтоод байсан бөгөөд үүний дараа ардчилсан улс болсон. Бразил улс одоогийн үндсэн хуулиа 1988 онд баталсан. Дэлхийн банкны гаргасан судалгаанаас харахад Бразил нь дунджаас дээгүүр орлоготой шинээр аж үйлдвэржсэн орон юм. Бразил улс дэлхийд дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ 10-аар байранд, хүний хөгжлийн индексээрээ 84-ээр байранд жагсдаг. Бразил улс сүүлийн 150 жилийн турш үйлдвэрлэж буй кофеныхоо хэмжээгээр дэлхийд тэргүүлж байна. Тус улсын газар тариалангийн аж ахуй эрхлэхэд таатай уур амьсгал кофены үр их хэмжээгээр ургах нөхцөл байдлыг бүрэн бүрдүүлж өгдөг ба нэг бразил хүн жилд дунджаар 5.5 килограмм кофе хэрэглэдэг гэх тооцоо байдаг. Бразил улс дэлхийн 10 дахь том төмөр зам болон гурав дахь том авто замын сүлжээтэй.

Дэлхийн хамгийн том хөгжиж буй эдийн засагтай улсын нэг Бразил нь дэлхийн 6 дахь том автомашины зах зээл болсон улс юм. Бразил улсын автомашины аж үйлдвэр 2017 онд бараг 60 тэрбум ам.долларын орлого олж байсан бол 2022 он гэхэд дэлхийн тэргүүлэх арван орны тоонд орох төлөвтэй байна.



Зах зээлийг импортын тариф, квот хэлбэрээр хамгаалах нь компаниудыг Бразилийн нутаг дэвсгэрт автомашины үйлдвэрлэлийн байгууламж нээх эсвэл өргөжүүлэхэд түлхэц болсон нь орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

2018 оны байдлаа Бразилийн автомашины үйлдвэр таван сая гаруй автомашин үйлдвэрлэх хүчин чадалтай болсон ба 130 мянга гаруй шинэ ажлын байр бий болж 2 сая гаруй тээврийн хэрэгсэл үйлдвэрлэсэн байна.

Бразилийн эдийн засаг сүүлийн жилүүдэд огцом сэргэж эхэлсэн тул моторт тээврийн хэрэгслийн борлуулалт 2018 онд 2.5 сая болж өссөн нь өмнөх жилээс 12%-иар өссөн үр дүнтэй байна.

Бразил улсад BYD, Fiat, Volkswagen Group, Ford, General Motors, Nissan Motors, Toyota, MAN, SE, Mitsubishi, Mercedes, Benz, Renault, Honda, Hyundai, Kia, Volvo, BMW, Subaru, Chery, Geely, Lifan, Peugeot, JAC, Porsche, Audi, Citroën, Jeep Land Rover, Mini, Lexus гэх мэт дэлхийн брэнд загварын автомашинуудыг үйлдвэрлэгч, дотоодын Troller, Marcopolo S.A., Agrale, Randon S.A., Excalibur гэх мэт компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

2011 онд Бразилд автомашины борлуулалт 3.633 сая ширхэг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.4%-иар өссөн байна. Гэсэн хэдий ч Бразил дахь автомашины борлуулалт 10-12-р саруудад жилийн өмнөхөөс буурсан байна; 2012 оны 1-3 дугаар сард мөн 0.8%-иар буурсан байна. 2011 онд импортын автомашины борлуулалт 30.0%-иар өсч 858,000 ширхэг болсон нь зарим талаараа бодит үнийн өсөлт; импортын автомашины эзлэх хувь 23.6%-д хүрчээ. Импортын автомашинуудаас дотооддоо автомашин үйлдвэрлэдэггүй Солонгос, Хятадын OEM компаниудын импорт 200,000-аас давжээ.

Бразилийн засгийн газар импортын автомашины өсөлтийг багасгах, хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилгоор 2011 оны 12-р сард импортын автомашины татварын хувь хэмжээг "IPI (Үйлдвэржүүлсэн бүтээгдэхүүний татвар)"-ын хэмжээг 30 пунктээр нэмэгдүүлсэн.

2012 оны 3-р сард Бразилийн засгийн газар Мексикээс импортын өсөлтийг хязгаарлахыг хүсч, Мексикийн засгийн газартай тохиролцоонд хүрсэн. 2012 оны 3-р сараас 2015 оны 3-р сар хүртэлх гурван жилийн хугацаанд засгийн газар Мексикээс импортын татваргүй барааны үнийн дээд хязгаарыг тогтоодог (2012 оны дээд хэмжээ нь 2011 оны бодит импортын үнийн дүнгийн 70% байна).

2011 онд Солонгос, Хятадын үйлдвэрүүд Бразил дахь импорт, борлуулалтыг ихээхэн нэмэгдүүлсэн боловч импортын автомашины IPI татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээс хойш хэд хэдэн OEM одоо Бразилд дотооддоо машин үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

2011 онд Аргентин улс 829,000 болон 884,000 автомашин үйлдвэрлэж, дээд амжилт тогтоосон байна. Үйлдвэрлэлийн 60 гаруй хувийг экспортлодог; Бразилд худалдаалагдаж буй тээврийн хэрэгслийн 60 гаруй хувийг импортын автомашин эзэлсээр байна. Аргентины засгийн газар дотооддоо тээврийн хэрэгсэл үйлдвэрлэдэг OEM компаниуд экспортоо нэмэгдүүлэхийг хүсч, Мексикийн засгийн газраас Бразилд хийдэг экспортыг хязгаарлах арга хэмжээ авахыг хүсч байна.

Холбогдох тайлангууд:

Бразил: Fiat/VW/GM 2014 онд тус бүр 1 сая автомашин борлуулахаар төлөвлөж байна (2011 оны 1-р сар)

Мексик/Бразил дахь Японы ханган нийлүүлэгчид: үйлдвэр барьж, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр яарав (2012 оны 2-р сар)

Бразилд автомашины борлуулалт 2011 оны 10-р сараас эхлэн жил ирэх тусам буурч, импортын автомашины борлуулалт нэмэгдсэн байна.

2011 онд Бразилд автомашины борлуулалт өмнөх оны мөн үеэс 3.4%-иар өсч 3.633 сая ширхэг болсон байна. Гэсэн хэдий ч аравдугаар сараас арван хоёрдугаар сарын хугацаанд Бразилд эдийн засгийн хэт халалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний дотор зээлийн хязгаарлалтын улмаас борлуулалт өмнөх оны мөн үеэс буурсан байна. Мөн 2012 оны 1-3 дугаар сард борлуулалт

0.8%-иар буурсан байна. Бразилд үйлдвэрлэсэн автомашин болон импортын автомашины дотор импортын автомашины борлуулалт 30.0%-иар өсч 858,000 ширхэг болсон нь бодит ханшийн тодорхой хэмжээгээр өссөн (2009 оны эхэн үеийн ханшаас ам.доллартай харьцах ханш 32%-иар өндөр), Бразилд үйлдвэрлэсэн автомашины борлуулалт тодорхой хэмжээгээр өссөнөөс шалтгаалж байна. 2.8%-иар буурч 2.775 сая ширхэг болсон байна. Импортын автомашины эзлэх хувь 23.6% болж өссөн байна.

Импортын автомашины дотроос дотооддоо машин үйлдвэрлэдэггүй, харин зөвхөн импортын машин зардаг (Тэдгээр нь ANFAVEA (Бразилийн Авто тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгчдийн үндэсний холбоо)-ны гишүүн биш бөгөөд гол төлөв Солонгос, Хятадын OEM үйлдвэрлэдэг) OEM-уудын борлуулалт бараг хоёр дахин нэмэгдэж, 202,000 ширхэг болжээ.

Бразилд үйлдвэрлэсэн автомашины борлуулалт буурснаас хойш Бразилийн автомашины үйлдвэрлэл 2011 онд ердөө 0.7%-иар бага зэрэг өссөн бол 2012 оны 1-3-р сард 10.9%-иар буурсан байна.

### 2.1.2. БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛС

Үзүүлэлт	Дүн
Хүн амын тоо (2021 он)	6 636 803 <sup>16</sup>
Газар нутгийн хэмжээ (км <sup>2</sup> )	199,945 <sup>17</sup>
Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо (2020 оны 12 сар)	1,412,206 <sup>18</sup>
Замын зорчих хэсэг дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл	Баруун

1998 оны 04 сарын 20-ны өдөр Киргиз Улс Замын хөдөлгөөний тухай хуулийг баталсан<sup>19</sup>. Энэхүү хуулиар тус улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний

<sup>16</sup> <http://www.stat.kg/en/opendata/category/312/>

<sup>17</sup> <https://www.britannica.com/facts/Kyrgyzstan>

<sup>18</sup> [https://24.kg/english/176746\\_State\\_Registration\\_Service\\_presents\\_top\\_10\\_vehicle\\_brands\\_in\\_Kyr\\_gyzstan/](https://24.kg/english/176746_State_Registration_Service_presents_top_10_vehicle_brands_in_Kyr_gyzstan/)

<sup>19</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kg/60?cl=ky-kg>

аюулгүй байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хохирлыг бууруулах замаар нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Тус хуулийн 14 дүгээр зүйлд тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгслийг үйлдвэрлэх, борлуулах үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс үндсэн шаардлагуудыг тодорхойлсон<sup>20</sup>. Тухайлбал, Бүгд Найрамдах Киргиз улсад үйлдвэрлэсэн, эсхүл гадаадаас 6 сараас дээш хугацаагаар оруулж ирсэн тус улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцох зорилготой тээврийн хэрэгсэл, түүнчлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай үүднээс тээврийн хэрэгслийн бүтцийн эд анги, нэмэлт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэрэг нь холбогдох техникийн зохицуулалтыг дагаж мөрдсөн үед зах зээл дээр борлуулагдах ба тэдгээрт хөрвүүлэг хийхийг зөвшөөрдөг байна.

Түүнчлэн, тус хуулийн 14.3-т заасны дагуу Бүгд Найрамдах Киргиз Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл нь (олон улсын аялалд оролцох буюу 6 сараас илүүгүй хугацаагаар гадаадаас авчирснаас бусад) Киргиз улсын хууль тогтоомжийн дагуу бүртгүүлж, зохих бичиг баримтыг бүрдүүлснээр зорчих боломжтой болдог. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тогтоосон шаардлагыг хангаж байгааг баталгаажуулсан бичиг баримтгүй тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглодог. Мөн хуулийн 14.4-т замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй бүртгэлтэй тээврийн хэрэгслийн загвар, түүний дотор эд анги, дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, багаж хэрэгслийн загварт оруулсан өөрчлөлт нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн байх тухай заажээ. Энэхүү заалтыг 2015 оны 01 сарын 15-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр оруулсан.

2015 оны 02 сарын 26-ны өдөр тус улсын Ерөнхийлөгч асан А.Атамбаев дээрх хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан<sup>21</sup>. Ингэхдээ хуулийн 2 дугаар зүйлд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл, зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл гэх тодорхойлолтыг хуульд шинээр заажээ. Тус хуулийн 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Киргиз улсын нутаг дэвсгэр дээр

---

<sup>20</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kg/60?cl=ky-kg>

<sup>21</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kg/205461?cl=ky-kg>

нийтийн аж ахуй, газар тариалан, зам барилгын (засвар үйлчилгээ)(кран, өрмийн машин, бетон зуурагч машин, шүршигч угаалгагч машин) болон Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газраас тогтоосон тээврийн хэрэгслээс бусад тохиолдолд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг бүртгэх, ашиглах, замын хөдөлгөөнд оруулахыг хориглоно” гэжээ.

Харин Бүгд Найрамдах Киргиз Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэд 6 сараас илүүгүй хугацаагаар буцаан авах үүрэгтэйгээр авчирсан болон олон улсын хөдөлгөөнд оролцож буй ялгах бүртгэлийн тэмдэг бүхий тээврийн хэрэгслийг өмчлөлийн зүйлд тооцохгүй ба улсын бүртгэлд бүртгэдэггүй.

Бүгд Найрамдах Киргиз Улсын Замын хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө оруулж ирсэн баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэлд энэ хуулийн үйлчлэх хүрээ хамаарахгүй” гэж заасан.

Мөн хуулийн үйлчлэлийг албан ёсоор нийтэлсэн өдрөөс хойш гурван сарын дараа дагаж мөрдөхөөр заасан<sup>22</sup>. Түүнчлэн, Засгийн газар нь тус хуульд заасан арга хэмжээ авах, шийдвэр гаргах үүрэг хүлээжээ. Замын хөдөлгөөний дүрмийн тухайд баруун гар талын дүрмээр зорчих тухай тэмдэглэсэн байдаг<sup>23</sup>.

Тус улсын Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 438 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Киргиз Улсын нутаг дэвсгэрт импортлохыг зөвшөөрсөн баруун гар талдаа жолооны хүрдтэй тусгай тээврийн хэрэгслийн жагсаалтыг баталсан<sup>24</sup>. Эдгээр тээврийн хэрэгсэлд барилгын болон нийтийн эзэмшлийн авто замын техникийн нөхцөлийг сайжруулах зорилготой кран, өрөмдлөгийн машин, машин-бетон зуурагч, нийтийн хэрэгцээнд зориулж угаагч, ус цацагч, хогны машин, цас цэвэрлэх машин, бохирын машин, гал унтраах машин, онцгой байдлын аврах машин, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хангах трактор, өөрөө явагч технологийн машин зэрэг тус тус багтдаг<sup>25</sup>.

---

<sup>22</sup> Бүгд Найрамдах Киргиз Улсын Замын хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйл.

<sup>23</sup> Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын 1999 оны 8-р сарын 4-ний өдрийн 421 тоот тогтоолоор Замын хөдөлгөөний дүрмийн 1.4-р зүйл.

<sup>24</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kg/100160?cl=ky-kg#%D1%801>

<sup>25</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kg/100160?cl=ky-kg#%D1%801>

Түүнчлэн, Киргиз Улс 2013 оны 07 сарын 19-ний өдөр Автотээврийн тухай хуулийг баталсан<sup>26</sup>. Энэхүү хуулиар автотээврийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Тухайлбал, зорчигч болон ачаа тээвэр, ачааны автомашин, автобус, суудлын автомашин, түүний дотор автомашины чиргүүл, хагас чиргүүл зэрэг ачааг тээврийн нийтлэг нөхцөл, түүнчлэн зорчигч, хөлслөгч, ачаа илгээгч, хүлээн авагчийн нөхцөл журмыг тогтоосон.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6-д “Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашиныг ашиг олох зорилгоор зорчигч, ачаа, бараа тээвэрлэхэд ашиглахыг хориглоно” гэжээ<sup>27</sup>. Энэхүү заалтын үйлчлэлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж тусгайлан заасан.

Энэхүү заалтыг Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө салшгүй байх, хүндэтгэн баталгаажуулах, хувийн өмчтэй байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх зэрэг холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж шүүхээр хянуулах тухай гомдлыг иргэн Мирлан Зарлыкович Мусаев гаргасан. Тус гомдлыг Киргиз Улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхим 2016 оны 11 сарын 16-ны өдөр авч хэлэлцээд 7 дугаартай шийдвэрээр<sup>28</sup> Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй хэмээн дүгнэжээ. Шүүхийн зүгээс тус хуульд заасан хязгаарлалтыг зайлшгүй шаардлагатай бөгөөд пропорциональ зарчимд нийцсэн, замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн мөн бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах, хамгаалах зэрэг үндсэн хуулийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилготой байна гэж үзсэн байна<sup>29</sup>.

Мөн тус хуулийн 56 дугаар зүйлийн 2-т Киргиз улсын Засгийн газар баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг Киргиз улсын нутаг дэвсгэрт импортлоход хязгаарлалт тавих зорилгоор албан ёсоор мэдэгдсэнээс хойш 6 сарын дараа тарифын болон тарифын бус хязгаарлалтын арга хэмжээ авна гэжээ.

Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 23 -ны өдрийн 407 дугаар тогтоолоор батлагдсан Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл,

---

<sup>26</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/203963>

<sup>27</sup> [http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/203963?cl=ky-kq#st\\_56](http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/203963?cl=ky-kq#st_56)

<sup>28</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/9675?cl=ky-kq>

<sup>29</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/9675?cl=ky-kq>



жолоочийн цахим мэдээллийн санг зохион байгуулах, хөтлөх журам 7.2-т Тээврийн хэрэгслийн мэдээллийн бүртгэлд жолооны хүрдний байршлыг тэмдэглэх тухай заасан байдаг<sup>30</sup>.

Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газрын 1999 оны 08 дугаар сарын 04 -ны өдрийн 421 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх бүхий этгээдийн үүрэг ба тээврийн хэрэгслийг ашиглах зөвшөөрөл <sup>31</sup> ”-н журмын 7.14-т Тоормосны систем, жолоодлогын удирдлага ажиллагаагүй болсон болон бусад хэрэгсэл, энэхүү жагсаалтад заасны дагуу бүтээгдсэн эсхүл тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч, бусад эрх бүхий байгууллагатай тохиролцоогүйгээр нэмэлт элементүүдийг суурилуулсан бол ашиглахыг хориглодог.

Олон нийтийн зүгээс баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашинууд зам тээврийн осолд өртөх нь ихэссэнтэй холбогдуулан эрх бүхий байгууллага дээрх шийдвэрийг гаргасан гэж үздэг. Энэхүү хууль батлагдахаас 10 орчим жилийн өмнөөс баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины импорт, бүртгэлийг хязгаарлах тухай яригдаж байсан. Тухайлбал, хуулийн төслийг 2010 онд тус улсын парламент баталсан ч иргэдийн эсэргүүцсэн жагсаал цуглааны улмаас ерөнхийлөгч гарын үсэг зураагүй байна.

Зохицуулалтын сул тал буюу эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудын зүгээс эрх мэдлээ урвуулан ашиглаж баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл бүртгэсэн тохиолдол гарсан болох нь нийтэд мэдээлэгдсэн<sup>32</sup>. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах улс төрийн санаачилга, холбогдох хуулийн өөрчлөлт болон ДЭМБ-н хамтын ажиллагааны үр дүнд 2017 оны байдлаар Киргиз улсад хүний амь нас хохирсон зам тээврийн ослын тоо буурсан<sup>33</sup>.

Тухайлбал, Киргиз Улсын Үндэсний статистикийн газрын мэдээллээр тус улсын нутаг дэвсгэр дээрх нийт зам тээврийн ослын тоо 2015 онд 7066 байсан бол 2016 онд 5868, 2017 онд 6346, 2018 онд 5995, 2019 онд 6663, 2020 онд 6126

---

<sup>30</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/100150/15?cl=ky-kq>

<sup>31</sup> <http://cbd.minjust.gov.kg/act/view/ky-kq/33665>

<sup>32</sup> <https://acca.media/en/2524/in-kyrgyzstan-a-corruption-scheme-for-import-and-registration-of-right-hand-drive-cars-was-revealed/>

<sup>33</sup> <https://kyrgyzstan.un.org/ky/12863-zhol-kyymylynyn-koopsuzdugu-kyrgyzstanda-olumgo-alyp-kelgen-zhol-transport-kyrsyktary>

болж буурсан байна<sup>34</sup>. Харин 2021 оны байдлаар нийт 7437 зам тээврийн ослын тохиолдол гарчээ.

Киргиз улсын Замын хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 02 сард олон нийтийн хэлэлцүүлэгт оруулсан. УИХ-ын гишүүн Марлен Маматалиевын санаачилсан нэмэлт, өөрчлөлт батлагдвал баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх боломж нээгдэх юм. Ийнхүү өөрчлөлт оруулах шалтгаан нөхцөлийн тухай нийтэд танилцуулахдаа *“импортоор орж ирдэг байсан баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашинууд чанар, тав тух, техникийн үзүүлэлтээрээ хамгийн сайн бөгөөд үйлдвэрлэсэн он шинэ тул экологид эергээр нөлөөлж, улсын ач холбогдол бүхий хотуудын утааны асуудлыг шийдвэрлэнэ”* гэж тодорхойлжээ<sup>35</sup>. Парламентын гишүүд баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашиныг улсын хилээр оруулж ирэхийг зөвшөөрч, нэг бол гүйцэж түрүүлэх камерыг заавал монитортой болгохыг санал болгож байна.

### 2.1.2. ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Үзүүлэлт	Дүн
Хүн амын тоо (2022 оны төлөв) <sup>36</sup>	5,134,000
Газар нутгийн хэмжээ (км <sup>2</sup> ) <sup>37</sup>	265,700
Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо (2021 он) <sup>38</sup>	4,497,463
Замын зорчих хэсэг дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл	Зүүн

Шинэ Зеланд улс нь 1997 онд батлагдсан “Эх газрын тээврийн журам: Жолооны удирдлагын систем”-д 2001 онд<sup>39</sup> нэмэлт өөрчлөлт оруулсан. Ийнхүү

<sup>34</sup> <http://www.stat.kg/en/opendata/category/4507/>

<sup>35</sup> [https://24.kg/english/224166\\_Draft\\_law\\_on\\_right-hand\\_drive\\_vehicles\\_submitted\\_for\\_public\\_discussion/](https://24.kg/english/224166_Draft_law_on_right-hand_drive_vehicles_submitted_for_public_discussion/)

<sup>36</sup> <https://www.britannica.com/facts/New-Zealand>

<sup>37</sup> <https://www.britannica.com/facts/New-Zealand>

<sup>38</sup> <https://www.statista.com/statistics/735099/new-zealand-currently-licensed-vehicles/>

<sup>39</sup> <https://www.nzta.govt.nz/resources/rules/steering-systems-2001/#:~:text=Land%20Transport%20Rule%3A%20Steering%20Systems%202001%20is%20one%20of%20a,steering%20systems%20in%20motor%20vehicles.>

нэмэлт өөрчлөлт оруулахдаа зохицуулалтын нөлөөнд өртсөн 800 гаруй сонирхогч хувь хүн, хуулийн этгээдийг албан ёстой хэлэлцүүлэгт оруулж журмын төсөлд тэдний саналыг тусгасан байна. Тус журам 2002 оны 04 сарын 01-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Энэхүү журам нь тус улсад хөдөлгөөнд оролцож буй моторт тээврийн хэрэгслийн систем болон эд ангийн аюулгүй байдлын шаардлага, стандартыг тогтоодог дүрмийн нэг юм. Энэхүү журмаар автомашины жолоодлогын системийн дизайн, үйлдвэрлэл, засвар үйлчилгээнд холбогдох харилцааг зохицуулдаг.

Тус журмын зорилго нь жолооны удирдлагын систем нь тээврийн хэрэгслийг аюулгүй, нарийн мэдрэгчтэй удирдлагаар хангах болон жолооны удирдлагын системтэй харьцаж байгаа эсхүл зам тээврийн осолд өртсөн үед жолоочийн гэмтэх эрсдэлийг бууруулах явдал юм.

Энэхүү дүрмийн зохицуулалтууд нь Шинэ Зеланд улс дахь тээврийн хэрэгсэл, зам тээврийн хөдөлгөөнтэй холбогдох:

- 1976 оны Замын хөдөлгөөний дүрэм,
- 1990 оны Автотээвэр (Тээврийн хэрэгслийн стандарт),
- 1998 оны Эх газрын тээврийн тухай хууль,
- 1998 оны Эх газрын тээврийн журам: Тээврийн хэрэгслийн стандартын нийцэл,
- 2001 оны Эх газрын тээврийн журам: Тээврийн хэрэгслийн урд бүс,
- 1999 оны Эх газрын тээврийн журам: Зөрчил, торгууль гэх эрх зүйн баримт бичгийн зохицуулалтуудтай уялддаг.

Журмын хамрах хүрээ нь бүх моторт тээврийн хэрэгсэл, түүний дотор 2-р хэсгийн хүснэгт А ангиллын тээврийн хэрэгслийн жолоодлогын удирдлагад шууд болон шууд бусаар нөлөөлж болох жолооны хүрд, холбогдох систем, эд ангиудад хамаарна. Эх газрын тээврийн журам: Жолоодлогын систем-д заасны

дагуу зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг журамд зааснаас бусад тохиолдолд бүртгэх, ашиглах, гэрчилгээжүүлэх нь хууль бус байдаг<sup>40</sup>.

Журамд дараах тохиолдлыг зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг хүлээн бүртгэх ашиглахыг хүлээн зөвшөөрсөн. Үүнд:

а) Ангилал тус бүрд заасан нөхцөлийг харгалзан 1-р жагсаалтад заасан тээврийн хэрэгсэл;

б) 2010 оны 4-р сарын 1-нээс өмнө Шинэ Зеландад ашиглалтад орох гэрчилгээ авсан зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл зэрэг багтана.

Бүртгэхийг зөвшөөрсөн зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн үндсэн ангилалд дараах хамаарна<sup>41</sup>. Үүнд:

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Тайлбар
1	<b>А төрөл</b> 20-с доош насжилттай тусгай зориулалтын хөнгөн тээврийн хэрэгсэл (light vehicles)	Тээврийн хэрэгсэл нь МА <sup>42</sup> ангиллын байх ёстой, Түүнчлэн: -Шинэ Зеландийн Тээврийн агентлаг зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн А ангиллын зөвшөөрөл олгосон байх, -Автомашиныг Шинэ Зеландад нэвтрэх гэрчилгээ авахаас 20-иос доошгүй жилийн өмнө Шинэ Зеландаас өөр улсад үйлдвэрлэсэн байх ёстой. Тээврийн хэрэгсэл нь тээврийн үйлчилгээ эрхэлдэггүй бөгөөд анхдагч А төрлийн тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг дөрвөн жилийн хугацаагаар авсан хүний нэр дээр бүртгүүлсэн байх ёстой. Шинэ Зеландийн Тээврийн агентлаг А төрлийн зөвшөөрөл олгохын тулд тухайн тээврийн хэрэгслийг түүхэн үнэ цэнэтэйд тооцогдох эсхүл дараах дөрвөн шаардлагын гурав хүртэлхийг хангаж үйлдвэрлэгдээгүй байх ёстой гэж үздэг. Үүнд: -Тээврийн хэрэгсэл (эсвэл түүний үйлдвэр, загвар,

<sup>40</sup> <https://www.nzta.govt.nz/vehicles/importing-a-vehicle/exceptions/importing-a-left-hand-drive-vehicle/>

<sup>41</sup> <https://www.nzta.govt.nz/vehicles/importing-a-vehicle/exceptions/importing-a-left-hand-drive-vehicle/>

<sup>42</sup> Есөөс илүүгүй суудалтай (жолоочийн суудлыг оролцуулаад) (МВ эсвэл МС ангиллаас бусад) суудлын тээврийн хэрэгсэл. <https://www.nzta.govt.nz/vehicles/vehicle-types/vehicle-classes-and-standards/vehicle-classes/#MA>

		<p>дэд загвар) нь арилжааны зорилгоор үйлдвэрлэсэн автомашин цуглуулагчийн эд зүйл гэж тодорхойлсон байдаг.</p> <p>-Тээврийн хэрэгслийн үйлдвэр, загвар, дэд загвар нь жилд 20,000 ширхэг ба түүнээс бага хэмжээгээр үйлдвэрлэж байгаа (эсвэл байсан) (сэв, зураастай машин нь энэ шалгуурыг хангахгүй бөгөөд LVV гэрчилгээтэй байж болохгүй)</p> <p>-Энэхүү тээврийн хэрэгсэл нь хоёр хаалгатай купе эсвэл хөрвөх боломжтой загвартайгаар үйлдвэрлэгдсэн</p> <p>-Энэхүү тээврийн хэрэгсэл нь өндөр хүчин чадалтай тээврийн хэрэгсэл болж үйлдвэрлэгдсэн.</p> <p>Тус улс жилд 500 хүртэлх А төрлийн тээврийн хэрэгслийн зөвшөөрөл олгодог.</p>
2	<b>Б төрөл</b> 20 ба түүнээс дээш насжилттай хөнгөн тээврийн хэрэгсэл	<p>20 ба түүнээс дээш жилийн өмнө үйлдвэрлэгдсэн эсхүл түүнээс ч өмнө Шинэ Зеланд улсад гэрчилгээ авсан тээврийн хэрэгсэл хамаарна. Энэ төрлийн тээврийн хэрэгсэл нь тээврийн үйлчилгээнд ашиглагдахгүй</p> <p>3.5 тонноос ихгүй жинтэй МА, МВ<sup>43</sup> эсхүл МС<sup>44</sup> ангиллын 20 ба түүнээс дээш жилийн өмнө Шинэ Зеланд улсаас өөр улсад үйлдвэрлэгдсэн түүнээс ч өмнө гэрчилгээ авсан байх ёстой.</p>
3	<b>С төрөл</b> Тусгай төрлийн тээврийн хэрэгсэл	<p>С1:Хосолмол жолоодлогын удирдлагатай тээврийн хэрэгсэл.</p> <p>Тээврийн хэрэгсэл нь хосолмол жолооны багана, удирдлагатай байх ёстой.</p>

<sup>43</sup> Урдаа удирдлагатай суудлын тээврийн хэрэгсэл (МС ангиллын тээврийн хэрэгслээс бусад):

- Есөөс илүүгүй суудалтай (жолоочийн суудлыг оролцуулаад) болон;
- Жолооны хүрдний төв нь тээврийн хэрэгслийн нийт уртын урд хэсэгт байрладаг.

<https://www.nzta.govt.nz/vehicles/vehicle-types/vehicle-classes-and-standards/vehicle-classes/#MA>

<sup>44</sup> Бартаат замын хөдөлгөөнд зориулагдсан, есөөс илүүгүй суудалтай суудлын тээврийн хэрэгсэл (жолоочийн суудлын байрлалыг оруулаад) Мөн:

-Дөрвөн дугуйгаар хөтлөгчтэй:

-Тээврийн хэрэгсэл нь тэгш гадаргуу дээр ачаагүй, урд дугуй нь тээврийн хэрэгслийн уртааш гол шугамтай параллель, дугуй нь тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн санал болгож буй даралтаар дүүрсэн үед дор хаяж дөрвөөс доошгүй шинж чанартай байна.

-28 градусаас багагүй ойртох өнцөг (an approach angle);

-14 градусаас багагүй эвдрэх өнцөг (a breakover angle);

-20 градусаас багагүй хөдлөх өнцөг (a departure angle);

-200 мм-ээс багагүй гүйлтийн зай (a running clearance);

-урд тэнхлэгийн зай, хойд тэнхлэгийн зай эсвэл дүүжлүүрийн зай 175 мм-ээс багагүй байна (front-axle clearance, rear-axle clearance or suspension clearance).

	<p><b>С2:</b>Зарим тохиолдолд Зүүн гар талдаа жолооны хүрдтэй байж болохоор тусгайлсан тодорхойлсон тээврийн хэрэгсэл.</p>	<p>Тээврийн хэрэгслийг дангаар нь эсвэл үндсэндээ дараахь байдлаар ашиглах ёстой.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Хөдөлгөөнт кран;</li> <li>-Өөрөө зам дээр бүрэн буюу хэсэгчлэн ажилладаг тээврийн хэрэгсэл;</li> <li>-Хөдөө аж ахуйн трактор, өөрөө явагч хөдөө аж ахуйн ургац хураах машин;</li> <li>-газар шорооны ажлын машин.</li> </ul> <p>Шинэ Зеландийн Тээврийн агентлаг нь тухайн тээврийн хэрэгслийн үйл ажиллагаа нь зүүн гар талдаа жолооны хүрдтэй болохыг эсвэл зөвхөн зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэлд ашиглах боломжтой гэдгийг бичгээр баталгаажуулах ёстой.</p>
	<p><b>С3:</b>Зүүн гар талдаа жолооны хүрдтэй байж болох бусад тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл.</p>	<p>Шинэ Зеландийн Тээврийн агентлаг нь тухайн тээврийн хэрэгсэл нь тусгай шинж чанартай, эсвэл үйл ажиллагааны тусгай зориулалтаар тоноглогдсон, баруун гар талдаа жолоодлоготой жолоодлоготой байх боломжгүй гэдгийг бичгээр баталгаажуулах ёстой.</p>
	<p><b>С4:</b>Зүүн гар талдаа жолооны хүрдтэй цогцос тээвэрлэх оршуулгын машин.</p>	<p>Тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгчээс уг машиныг цогцос тээвэрлэх оршуулгын машин гэж тодорхойлсон байх ёстой.</p>
	<p><b>С5:</b>Зүүн гар талдаа жолооны хүрдтэй мотоспортын машинууд</p>	<p>Тээврийн хэрэгсэл нь моторт спортын тэмцээнд ашиглагддаг МА эсвэл МС ангиллын моторт тээврийн хэрэгсэл байх бөгөөд хүчин төгөлдөр моторт спортын холбогдох зааврын нөхцлийн дагуу ашигладаг байх ёстой.</p>
4	<p><b>Д төрөл</b> Дипломат төлөөлөгчдийн тээврийн хэрэгсэл</p>	<p>Тээврийн хэрэгслийг дипломат халдашгүй дархан эрхтэй хүн ашигладаг байх ёстой ёстой. Зохих итгэмжлэлийн бичгээр дипломат статусаа нотлох шаардлагатай.</p>
5	<p><b>Е төрөл</b> Бүртгэл, зөвшөөрлөөс чөлөөлөгдсөн тээврийн</p>	<p>Хувийн замд явж байгаа тээврийн хэрэгслийг бүртгүүлэх шаардлагагүй (Хувийн зам гэдэг нь тухайн газрын өмчлөгчийн хувийн газар дээр байгуулсан зам, газрыг хэлнэ). Түүнчлэн, дор дурдсанаас бусад үед улсын бүртгэлд</p>



	хэрэгсэл <sup>45</sup>	<p>бүртгэгдээгүй тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох нь зөрчилд тооцогддог. Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Айлчлал хийж буй цэргийн хүчний албан ёсны тээврийн хэрэгсэл;</li> <li>-Энгийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хаалттай зам дээр ажиллаж байгаа тээврийн хэрэгсэл;</li> <li>-Өөрийн хүчийг ашиглахгүйгээр түр чирүүлж байгаа тээврийн хэрэгсэл;</li> <li>-Үйлдвэрлэлийн тусгай зориулалтаар трактор, зтгүүрийн хөдөлгүүр, өргөгч, өөрөө явагч машинд зэрэгт бэхлэгдсэн чиргүүл;</li> <li>-Хөдөө аж ахуйн зориулалттай өөрөө явагч машинд бэхлэгдсэн чиргүүл;</li> <li>-Зөвхөн хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд зориулагдсан, ферм рүү ирэх, явах, үзлэг, засвар үйлчилгээ авах үедээ зам ашигладаг чиргүүл;</li> <li>-2004 оны Газрын тээврийн менежмент (Онцгой албан татвар, түүнтэй адилтгах албан татварыг хуваарилах, буцаан олгох) журамд заасны дагуу чөлөөлөгдсөн тээврийн хэрэгсэлд хавсаргасан чиргүүл;</li> <li>-Гадаадаас ирсэн жуулчдын тээврийн хэрэгсэл. Үүнд гадаадаас ирсэн жуулчдын гадаадад бүртгэлтэй, Шинэ Зеландад 18 сараас бага хугацаагаар байх машиныг ойлгодог.</li> </ul>
6	<b>Ф төрөл</b> Хааны өмнө ашиглаж байсан тээврийн хэрэгслүүд	Тээврийн хэрэгсэл нь өмнө хааны өмчлөлд байсан байх ёстой.
7	<b>Г төрөл</b> Хажуу талдаа суудалтай мотоцикл	Мотоцикл нь мотоциклийн баруун гар талд суурилуулсан хажуугийн суудалтай байж болно.

Түүнчлэн, 2010 оны 4-р сарын 1-нээс өмнө Шинэ Зеландад нэвтэрсэн зүүн гар талдаа жолооны хүрдтэй автомашинууд болон Шинэ Зеландад түр хугацаагаар импортлогдсон тээврийн хэрэгслүүдийг үргэлжлүүлэн бүртгэх боломжтой тухай заасан<sup>46</sup>.

<sup>45</sup> <https://www.nzta.govt.nz/vehicles/licensing-rego/exemptions/exemption-from-registration/>

<sup>46</sup> <https://www.nzta.govt.nz/vehicles/importing-a-vehicle/exceptions/importing-a-left-hand-drive-vehicle/>

Жолоодлогын удирдлагын систем 2001 журмын 2 ба 3-р хэсэг<sup>47</sup>-т тээврийн хэрэгслийн жолооны хүрдтэй холбоотой дараах үндсэн зохицуулалт тусгагдсан.

Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн чиглэлийн удирдлага<sup>48</sup>д шууд болон шууд бусаар нөлөөлөх тээврийн хэрэгслийн жолоодлогын удирдлагын систем болон холбогдох систем, эд ангиудад дараах шаардлагыг хангасан байх ёстой.

а) дуу чимээ болон тохиромжтой нөхцөлд байх бөгөөд тээврийн хэрэгслийг аюулгүй, үр ашигтай, тохиромжтой, нарийн мэдрэгчтэй удирдлагаар хангагдах;

б) бат бөх, удаан эдэлгээтэй, зорилгодоо тохирсон байх бөгөөд холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийн ашиглах хамгаалалтын системийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас сөрөг үр дагавар гарж байгаа эсэхийг харгалзан үзэх.

2. 50 км/цаг-аас дээш хурдлах чадвартай, жолооны удирдлагын системээр тоноглогдсон, жолоочийн удирдах хэрэгсэл, дугуй болон тээврийн хэрэгслийн чиглэлийг өөрчлөх бусад хэрэгслийн хооронд шууд механик холболтгүй тээврийн хэрэгсэл нь дор хаяж нэг 1-р шаардлагад нийцсэн жолоодлогын нэмэлт хэрэгсэлтэй байх ёстой.

3. Тээврийн хэрэгслийн жолоодлогын удирдлагад нөлөөлж болох жолоодлогын удирдлагын систем, бусад систем, эд ангид өөрчлөлт оруулах нь тээврийн хэрэгслийг 1-р шаардлагыг нийцүүлэхэд саад болохгүй.

4. Тээврийн хэрэгслийн жолоодлогын удирдлагад нөлөөлж болох жолоодлогын удирдлагын систем, бусад систем, эд ангид хийсэн өөрчлөлт нь гэрчилгээжсэн байх ёстой.

5. Чиглэлийн удирдлагад нөлөөлж болох жолоодлогын удирдлагын систем эсвэл системийн бүрэлдэхүүн хэсэг өөрчлөгдсөн тохиолдолд:

---

<sup>47</sup> <https://vehicleinspection.nzta.govt.nz/virms/hvsc/additional-topics/conversion-to-rh-drive#tab2>

<sup>48</sup> directional control.

а) жолоодлогын удирдлагын систем нь тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгчийн гүйцэтгэл, бүрэлдэхүүн хэсгийн техникийн үзүүлэлтүүд эсвэл анхдагч жолооны удирдлагын системтэй нийцсэн байх ёстой.

б) жолоодлогын удирдлагын систем ирж буй эд ангиудын ачаа ба даралт нь анх хэрэглэгдэж байсан үйлдвэрлэгчээс тогтоосон тусгай хэрэглээнд зориулсан загвар, гүйцэтгэлийн шалгуурт нийцсэн байх ёстой.

6. жолоодлогын удирдлагын системийн засвар, эсвэл жолоодлогын системд нөлөөлөх моторт тээврийн хэрэгслийн засвар нь энэ хэсэгт заасан бусад бүх шаардлагыг хангасан байх ёстой.

Сүүлийн үед үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгслийн хувьд ингэх нь зардал өндөр ба тээврийн хэрэгсэл нь урд талын нөлөөллөөс хамгаалах систем буюу хамгаалах дэр, хамгааллын хэсэг зэргээс үүдэн зүүн гар талдаа байрлах жолооны хүрдийг баруун тал руу шилжүүлэх боломжгүй байх эрсдэлтэй байна<sup>49</sup>.

Хүнд даацын тээврийн хэрэгслийн дүрэм<sup>50</sup> 6.5-р хэсгийн 8-д тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн талаас баруун талруу жолоодлоготой болгож өөрчилсөн бол дараах зүйлийг анхаарах тухай заажээ. Үүнд:

а) боломжтой бол анхдагч<sup>51</sup> тоног төхөөрөмжийг ашиглах;

б) тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгч, мэргэжлийн хяналт, баталгаажуулалт үйл ажиллагаа болон тусгай хяналт шалгалт гүйцэтгэхээр томилогдсон тээврийн хэрэгслийн байцаагч эсхүл хяналтын байгууллагаас зөвшөөрөл аваагүй бол анхдагч бус төхөөрөмжийг ашиглахыг хориглоно;

в) жолоодлогын баганын бүрэн бүтэн байдал, түүний нугаралтын механизмыг<sup>52</sup> өөрчлөхгүйгээр жолооны баганыг шилжүүлэх ёстой;

---

<sup>49</sup> <https://www.nzta.govt.nz/vehicles/importing-a-vehicle/exceptions/importing-a-left-hand-drive-vehicle/>

<sup>50</sup> <https://vehicleinspection.nzta.govt.nz/virms/hvsc/additional-topics/conversion-to-rh-drive#tab2>

<sup>51</sup> original equipment.

<sup>52</sup> collapse mechanism.

г) Тээврийн хэрэгслийн явах эд анги эсвэл их биенд бэхэлгээг бэхлэх дараах тохиолдлоос бусад үед жолооны эд ангиудыг гагнахыг хориглоно;

i. тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгч, мэргэжлийн хяналт, баталгаажуулалт үйл ажиллагаа болон тусгай хяналт шалгалт гүйцэтгэхээр томилогдсон тээврийн хэрэгслийн байцаагч эсхүл хяналтын байгууллагаас гагнуурын ажлыг загварлаж хийсэн;

ii. зохих үл эвдрэх туршилтыг мэргэшсэн хүн хийсэн.

д) жолоодлогын гүйцэтгэл, шинж чанаруудыг хадгалсан байх ёстой;

е) зогсоолын тоормос, туслах тоормос, холимогийн хаалт, авцуулах холбооны удирдлага тээврийн хэрэгслийн баруун гар талд шилжүүлсэн байх ёстой;

ё) зогсоолын тоормос, холимогийн хаалт, авцуулах удирдлагын шинэ бэхэлгээний цэгүүд нь анхдагч бэхэлгээний цэгүүдтэй тэнцэх чадалтай байх ёстой.

9. Тээврийн хэрэгслийг зүүн гар талдаа жолооны хүрдээс баруун гар талдаа жолоодлоготой болгосон бол:

а) үйлчилгээний тоормосны<sup>53</sup> хяналтын угсралтыг тээврийн хэрэгслийн баруун гар талд шилжүүлэх ёстой, эсхүл

б) тоормосны дөрөөний угсралтыг тээврийн хэрэгслийн баруун гар талд шилжүүлэх ба тоормосны дөрөөний хөдөлгөөнийг мастер цилиндр эсвэл гишгүүрийн хавхлагт дараах байдлаар дамжуулах ёстой.

i. эргүүлэх босоо ам<sup>54</sup>, эсвэл

ii. хөшүүрэг ба саваа<sup>55</sup>.

---

<sup>53</sup> service brake.

<sup>54</sup> a torque shaft.

<sup>55</sup> levers and rods.

10. 9-р шаардлагад хамаарах тээврийн хэрэгслийн хувьд үндсэн цилиндр буюу гишгүүрийн хавхлага болон тоормосны хүчийг баруун гар талаас зүүн гар тал руу шилжүүлэх механизм нь зөвхөн жолоочийн идэвхжүүлж болох үйлчилгээний тоормосоор хамгаалагдсан байх ёстой<sup>56</sup> гэжээ.

Харин тээврийн хэрэгслийг хосолмол удирдлагатай болгох тухай асуудлыг журмын 6.6-р хэсэгт заасан. Тухайлбал, зөвхөн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд хосолмол удирдлагатай жолоодлогод шилжүүлэх ажлыг хийдэг байна.

Тусгай зориулалтын автомашиныг хосолмол удирдлагатай болгосон бол:

а) боломжтой бол анхдагч тоног төхөөрөмжийг ашиглах;

б) тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгч, мэргэжлийн хяналт, баталгаажуулалт үйл ажиллагаа болон тусгай хяналт шалгалт гүйцэтгэхээр томилогдсон тээврийн хэрэгслийн байцаагч эсхүл хяналтын байгууллагаас зөвшөөрөл аваагүй бол анхдагч бус төхөөрөмжийг ашиглахыг хориглоно;

в) Тээврийн хэрэгслийн явах эд анги эсвэл их биенд бэхэлгээг бэхлэхээс бусад тохиолдолд жолоодлогын эд ангиудыг гагнахыг хориглоно. Үүнд:

i. тээврийн хэрэгсэл үйлдвэрлэгч, мэргэжлийн хяналт, баталгаажуулалт үйл ажиллагаа болон тусгай хяналт шалгалт гүйцэтгэхээр томилогдсон тээврийн хэрэгслийн байцаагч эсхүл хяналтын байгууллагаас гагнуурын ажлыг загварлаж хийсэн;

ii. зохих үл эвдрэх туршилтыг мэргэшсэн хүн хийсэн.

г) жолоодлогын гүйцэтгэл, шинж чанарыг хадгалах ёстой;

д) зогсоолын тоормос, холимогийн хаалт, авцуулах удирдлагын шинэ бэхэлгээний цэгүүд нь анхдагч бэхэлгээний цэгүүдтэй тэнцэх чадалтай байх ёстой.

Мөн түүнчлэн, тусгай зориулалтын автомашиныг хосолмол удирдлагатай болгосон бол:

---

<sup>56</sup> <https://vehicleinspection.nzta.govt.nz/virms/hvsc/additional-topics/conversion-to-rh-drive#tab2>

а) ашиглалтын тоормосны хяналтын угсралт нь гидравлик болон пневматик шугамын даралт нь ажиллахгүй байгаа гол цилиндр эсвэл гишгүүрийн хавхлагт үйлчлэхээс сэргийлж тээврийн хэрэгслийн нөгөө талд хуулбарлагдсан байх ёстой эсхүл,

б) тоормосны дөрөөний хөдөлгөөнийг гол цилиндр эсвэл гишгүүрийн хавхлагт дараахь байдлаар дамжуулах ёстой.

i. эргүүлэх босоо ам, эсвэл

ii. хөшүүрэг ба саваа.

Хосолмол жолоодлоготой болсон тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн жолоодлогын хөдөлгөөнийг гинж ба араа эсвэл налуу арааны хайрцгаар дамжуулж болно гэжээ. Дээрх бүхий л шаардлагад нийцүүлж хүнд даацын тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байрлалыг шилжүүлэн өөрчлөөгүй бол ийнхүү өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл болдог<sup>57</sup>.

## 2.2 Бүлгийн дүгнэлт

Тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчилж, нэгдсэн зохицуулалт бий болгосон улсуудын туршлагыг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Судлагдсан орнуудын хувьд тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг замын хөдөлгөөний батлагдсан талын эсрэг чиглэлд шилжүүлэхийн тулд тухайн улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай тохиолдолд холбогдох журам, стандартуудыг шинээр баталсан байна.
2. Замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах үндэслэлээр замын хөдөлгөөний батлагдсан талын эсрэг чиглэлд жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн тоог бууруулах, жолооны хүрдний байршлыг

---

<sup>57</sup> <https://vehicleinspection.nzta.govt.nz/virms/hvsc/additional-topics/conversion-to-rh-drive#tab1>



өөрчлөхийн тулд тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хязгаарлалтыг зохистой байдлаар тогтоох нь зүйтэй байна.

3. Судлагдсан орнуудын хувьд хууль, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл, зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл гэх нэр томъёог нэгдсэн ойлголтоор хэрэглэж, батлагдсан талын эсрэг чиглэлд жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг ямар тохиолдолд бүртгэх тухай тусгайлан жагсааж, жолооны хүрдний байршлыг өөрчилсөн тохиолдолд холбогдох техникийн шаардлагад нийцүүлсэн байх тухай зохицуулж өгчээ.
4. Жолооны хүрдний байршлаас шалтгаалж тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хязгаарлалт тогтоох нь олон этгээдийн эрх ашгийг хөндөж байх тул холбогдох хууль, тогтоомжийн өөрчлөлт, журам, стандартыг боловсруулах ажиллагаанд тэдгээрийг оролцуулж, холбогдох санал, дүгнэлтийг тусгаснаар үүсэж болох ирээдүйд үүсэж болох хүндрэлээс сэргийлэх боломжтойг практик харуулж байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- 1) Хууль, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл, зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл гэх нэр томъёог тодорхойлох, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзаж, хөдөлгөөнд оролцуулахыг хориглох, тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчлөх шаардлага болон ямар тохиолдолд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг бүртгэж, хөдөлгөөнд оролцуулахыг зөвшөөрөх тухай зохицуулалтыг тээврийн хэрэгслийн онцлогт нийцүүлж боловсруулах;
- 2) Жолооны хүрдний байршлыг өөрчилсөн тохиолдолд ямар техникийн шаардлагад хангах тухай үндэслэлийг техникийн шинжлэх ухаанд суурилж, аюулгүй байдлыг нийцүүлэх боловсруулах, тэрхүү өөрчлөлтийг хууль эрх зүйн хүрээнд хэн гүйцэтгэх, хэн, хэрхэн шалгах эрх хэмжээтэй байх тухай нэгдсэн зохицуулалт бий болгох;
- 3) Жолооны хүрдний байршлаас шалтгаалж тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах, жолооны хүрдний байршилд өөрчлөлт оруулах холбогдох

зохицуулалтыг боловсруулахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийг  
оролцуулах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, холбогдох саналыг  
тусгах;

### 3 ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ, ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГАА

---

Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолоодлогыг зүүн тал руу шилжүүлэн байрлуулах ажиллагаа нь энгийн процесс биш тул мэргэжилтний хяналт дор хийгдэх ёстой байдаг. RHD<sup>58</sup>-ийг LHD<sup>59</sup> болгон хувиргах явцад гарсан аливаа жижиг алдаа нь зөвхөн автомашинд төдийгүй жолоочид ч асуудал үүсгэж болзошгүй.

Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолоодлогыг зүүн тал руу шилжүүлэн байрлуулах ажил нь тухайн автомашины төрөл, хийцийн онцлог ялгаатай байдал зэргээс хамааран задлах, угсрах ажилбар нь өөр өөр байна. Тухайлбал: Тоёота фирмийн Харриер маркийн автомашины 2013 оноос хойш үйлдвэрлэсэн гуравдугаар цувралын XU60 загвар нь ZSU60 (FWD), ZSU65 (4WD), ASU60 (FWD), ASU65 (4WD), AVU65 (4WD) гэсэн 5 төрлийн ялгаатай үйлдвэрлэгдсэн. Эдгээр загваруудын зарим систем, механизм, эд ангийг задлах, угсрах технологи нь өөр өөр байна.

Иймд энэхүү бүлэгт дурдагдсан систем, механизм, эд ангийг өөрчлөн солихтой холбогдсон технологи, ажилбарыг гүйцэтгэхдээ тухайн автомашины үйлдвэрлэгчээс зөвлөсөн засварын гарын авлагыг баримтлах нь зүйтэй.

RHD-ийг LHD болгон хувиргахдаа дараах систем, агрегат, эд ангид өөрчлөлт оруулах шаардлагатай болдог. Үүнд:

1. Жолооны системийн эд ангийн байрлалыг өөрчлөх,
2. Хяналтын самбар, түүнд байрлах хэрэгслийг өөрчлөн шинэчлэх,
3. Их гэрлийн тусгалыг өөрчлөн тохируулах,
4. Тоормосны системийн эд ангийн байрлалыг шилжүүлэх,
5. Хажуугийн толины тохируулгыг өөрчлөх, шинэчлэх

зэрэг болно.

Мөн тухайн автомашины хүч дамжуулах ангийн хийцийн онцлогоос хамаарч авцуулах холбооны удирдлага, механизм, дөрөө болон бусад эд ангийг солих шаардлагатай болно.

---

<sup>58</sup> Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл

<sup>59</sup> Зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл

Дээр дурдсан систем, эд ангийг шинэчлэх, шилжүүлэх, тохируулах ажиллагааг доорх дэд бүлэгт нарийвчлан авч үзье.

### **3.1 Жолооны системийн эд ангийн байрлалыг өөрчлөх**

Жолооны аппаратыг шилжүүлэхдээ тухайн автомашины хийцийн онцлогоос хамааран дараах үндсэн аргыг ашиглаж байна. Үүнд:

1. Өөрийнх нь жолооны аппаратыг байрлалыг баруун талаас нь зүүн талд нь шууд шилжүүлэн байрлуулж, зүүн талын эд ангийг баруун талд нь шилжүүлэн боох. Энэ нь хялбар, хэмнэлттэй боловч зарим автомашинд хэрэглэх боломжгүй.
2. Дараагийн арга нь тохирох жолооны аппаратыг шинээр суурилуулах. Шинээр суурилуулах жолооны аппаратыг сонгохдоо дараах зөвлөмжийг мөрдөх шаардлагатай.
  - Суурилуулах жолооны аппарат нь тухайн буй тээврийн хэрэгслийн жин, техникийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж байх ёстой. Жолооны аппаратын хэдрэг арааны шилжих зай, өнцөг нь нэгэн ижил байх ёстой;
  - Хөндлөн татуургын бэхлэх конус нь тохирч байх ёстой.

Жолооны аппаратыг суурилуулахдаа жолооны хүрдний голын тэнхлэгийн чиглэл, хөндлөн татуургын холболтын дагуу чиглэлд зөв байрлуулсан байх ёстой.

Баруун гар талын бэхэлгээний хэсэг нь арлын зүүн гар талын бэхэлгээний хэсэгтэй адил давтагдан аралд суурилагдах ёстой.

Эд анги, шассид хийгдсэн аливаа өөрчлөлт хэт ачаалал үүсгэж болохгүй. түүний хүчийг бууруулж, стрессийн концентрацийг үүсгэж болохгүй. Ашиглалтын явцад жолооны аппаратаас гарах өндөр моментыг тооцох ёстой.

Жолооны хүрдний голыг зүүн гар тал руу шилжүүлж, жолооны аппарат болон жолоочийн байрлалд зөв тохируулсан байх ёстой.

Жолооны хүрдний голыг бүхэлд нь өөрийнх нь баруун гар талын сууринаас тайлж аваад бүхээгийн зүүн гар талд дахин угсардаг. Энэхүү бэхэлгээний бат бэх нь урд талаас мөргөлдөх үед ирэх жолооны голын ачааллыг бүрэн даахуйц байх ёстой тул анхны суурилуулалттай ижил хүч, хөшүүн байдлыг хангах ёстой.

Бүхээгт жолооны голын бэхэлгээ нь өмнөх угсарсан байдлын дагуу хийгдэх ёстой.

### **3.2 Хяналтын самбар, түүнд байрлах хэрэгслийг өөрчлөн шинэчлэх**

Жинхэнэ эсвэл тухайн автомашины ослын үеийн хамгаалалтын шаардлагыг хангасан хянах самбарын хавтанг ашиглах ёстой. Бүх хэмжих болон мэдээлэх хэрэгсэл, удирдлагыг зүүн гар талдаа жолооны хүрдтэй автомашиныхтай ижил байрлалд байрлуулах ёстой.

Бүх хавтангийн холболт нь бүрэн бэхлэгдсэн байх ёстой.

### **3.3 Их гэрлийн тусгалыг өөрчлөн тохируулах**


Автомашины агрегат, систем, механизм, цахилгаан системийн дотроос гэрэлтүүлэх хэрэгсэл нь харанхуй, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар онцгой байр эзэлдэг.

Их гэрлийг тусгалын тархалтаар нь америк буюу тэгш хэмтэй, европ буюу тэгш бус хэмтэй гэрлийн хувиргалттай гэж ангилдаг. Европ маягийн гэрэл хуваарилалтыг замын хөдөлгөөний дүрмийн ялгаатай байдлаас хамааран зүүн гарын дүрмээр хөдөлгөөний чигт нийцсэн, баруун гарын дүрмээр хөдөлгөөний чигт нийцсэн гэж ангилдаг.


Монгол улсын хууль эрх зүйн баримт бичигт нийцсэн зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн их гэрлийн тусгал нь өөдөөс ирж буй тээврийн хэрэгслийн жолоочийн нүдийг гялбуулахгүй, зорчих хэсгийн баруун гар талыг илүү сайн гэрэлтүүлэхээр техникийн шийдэлтэй байдаг.

Их гэрэл нь холын болон ойрын гэрлийн тусгалтай. Холын гэрэл нь автомашин өндөр хурдтай явж байх үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц **хязгаарт** зам ба түүний орчныг гэрэлтүүлж байхаар, ойрын гэрэл нь зам болон замын баруун (зүүн) гар талыг гэрэлтүүлэх бөгөөд зэрэгцээ тусгал нь өөдөөс ирж яваа жолоочийн нүдийг гялбуулахгүйгээр байх ёстой. Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөндөө баруун гарын дүрэм баримталдаг, европ стандартын холын ба ойрын гэрлийн тусгалын хэлбэр, гэрэлтүүлэх зайг 3.2 дугаар болон 3.2 дугаар зурагт үзүүлэв.

**Зураг 3-1 Ойрын гэрлийн тусгал (тэгш бус хэмт)**



**Зураг 3-2 Холын гэрлийн тусгал (тэгш хэмт)**



Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн их гэрлийн ойрын тусгал нь зорчих хэсгийн зүүн гар тал уруу илүү их талбай гэрэлтүүлдгээс өөдөөс ирж буй тээврийн хэрэгслийн жолоочийн нүдийг гялбуулж таагүй, аюултай байдал үүсгэдэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. Үүнээс шалтгаалж шөнийн цагаар осол гарах магадлал нэмэгдэх боломжтой гэж үздэг.

Иймд манай оронд ашиглагдаж байгаа зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгслийн их гэрлийн тусгалыг өөрчилж зөв тусгалтай болгох шаардлага тулгарч байна.

Монгол улсын MNS4598-2011 “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” стандартын 5.13.4. “Замын хөдөлгөөнд оролцогчдоод таагүй байдал үүсэхээс сэргийлж зүүн гар талын хөдөлгөөнд нийцсэн гэрлийн тусгалыг баруун гар талын хөдөлгөөнд нийцсэн гэрлийн тусгалтай болгож өөрчилж болно. Энэ тохиолдолд ойрын гэрлийн хүч 0.86D-1.72R цэгт 2500 кд-аас их, 0.57U-3.43L цэгт 880 кд-аас бага байна.” гэж тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл их гэрлийн тусгалыг өөрчлөхдөө НҮБ-аас гаргасан техникийн R112 дугаар зохицуулалтын 5.8.1 болон 5.8.2.2-т заалт, гэрлийн тусгалыг хэмжихдээ техникийн R48 дугаар зохицуулалтыг баримталдаг.


Их гэрлийн тусгалыг өөрчлөхдөө дараах үндсэн аргуудыг ашиглаж байна. Үүнд:

**1. Гэрлийн лампыг анхны байрлалаас цагийн зүүний эсрэг 30 эргүүлж тусгалын өнцгийг өөрчлөх арга.**

Ихэвчлэн H4 маркийн галоген ламптай их гэрлийн ойрын гэрлийн тусгалыг замын баруун гар тал руу тусдаг болгоход ашигладаг. бол гэрлийн цацрагийг өөрчлөх юм. Их гэрлийн лампын 3 сэртэнг 0,5 мм хэмжээтэй үлдээж тасалж авна. Ингэснээр уг ламп анхны байрлалаас цагийн зүүний эсрэг 30<sup>0</sup> эргүүлж суулгах боломжтой болдог. Лампыг тусгай бэлдцийн тусламжтайгаар лампын үүрэнд суулгаж, даруулгаар дарснаар хөдлөхгүй болно. Энэ арга нь зардал бага, хийц хялбар, энгийн байдгаараа давуу.

Лампын байрлалыг цагийн зүүний эсрэг 30 эргүүлэхийн тулд ашиглагдахгүй байгаа ижил төрлийн лампын тавгийг зурагт үзүүлсэн хэлбэрээр лампад бэхлэх ба тавгийн байрлал өөрчлөгдөж бэлэн болсон лампыг их гэрлийн фарны үүрэнд суулгаж дарагчаар цоожилж бэхэлнэ.

**Зураг 3-3 Бэлдэц суурилуулсан байдал**





Лампын тавагтай ижил хэмжээтэй тусгай бэлдэц ашиглаж 3.3 дугаар зурагт үзүүлсэн байдлаар бэхэлнэ. Энэ аргын давуу тал тусгай бэлдцийг олноор нь хийлгэвэл зардал бага гарна. Нэг загварын бэлдэц хэрэглэх тул гэрлийн тохиргоо алдагдахгүй. Ламп шатсан тохиолдолд солиход бэлдцийг дахин ашиглах боломжтой. Энэхүү аргыг ашиглан гэрлийн тусгалыг зөв болгох боломжтой юм.

## **2. Лампын тавгийг салгалж анхны байрлалаас нь цагийн зүүний эсрэг 30 эргүүлж буцаан бэхлэх арга**

Энэ аргын давуу тал нэмэлт материал шаардлагагүй. Гэвч ажиллагаа ихтэйгээ гадна цэгэн гагнуурын аппарат, тасдагч зэрэг нарийн тоног төхөөрөмж шаардлагатай.

## **3. Их гэрлийн гадна талд тусгай линз нааж тусгалыг өөрчлөх арга**

Энэ аргыг Европын орнуудад өргөн ашигладаг. Жишээлбэл: Англи улсын иргэд автомашинтайгаа Европын холбооны бусад улс руу түр зуур зорчиход тунгалаг наалт-линз хэрэглэдэг журам үйлчилдэг байна. Гэрэл ойлгогчоос урагш ойсон гэрлийн чигийг өөрчилж хугалах үүрэг гүйцэтгэдэг призм бүтэцтэй, гадаргууд наах зориулалттай жижиг хэмжээний тунгалаг өнгөтэй наалт-линз хэрэглэхийг Европын холбооны хуулиар зөвшөөрдөг байна.

Сайтар цэвэрлэсэн гэрлийн гадаргууд, ойрын гэрлээ асааж байгаад, наах цэгийг тодорхойлох цаасны тусламжтай гэрлийн төв цэгийг олоод линзээ наадаг. Наах цэгийг тодорхойлох цаас болон линзийг 3.4 дугаар зурагт үзүүлэв.

### **Зураг 3-4 Наах цэгийг тодорхойлох цаас болон линз**



Их гэрлийн гадаргууд линзний наасан байдлыг 3.5 дугаар зургаар үзүүлэв.

**Зураг 3-5** Их гэрлийн гадаргууд линзийг наасан байдал



Энэ линз нааж гэрлийн тусгалыг өөрчлөх арга нь хэрэглэхэд хялбар өртөг багатай боловч байнгын хэрэглээнд тохиромж муутай гэж үздэг.

Манай хөрш ОХУ-д 2010 оны 9-дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт” стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор гэрлийн тусгалын чиглэлийг өөрчлөхөд зориулагдсан нэмэлт оптик элементүүд /өнгөтэй, өнгөгүй оптик элемент, плёнк/ хэрэглэхийг зөвшөөрсөн заалтыг нэмэлт өөрчлөлтөөр оруулж, албан ёсоор хэрэглэхийг зөвшөөрсөн.

#### **4. Гэрлийн лампад нэмэлт хаалт хийж тусгалыг өөрчлөх арга**

Гэрлийн тусгалыг нэмэлт хаалтын тусламжтайгаар өөрчлөхдөө 5 мм өргөн, 7 см урт бэлдцийг бэлтгэнэ. Бэлдцээ лампынхаа цагийн зүүний 8 цагийн байрлалд бэхэлж тогтоодог. Н4 маркийн лампад нэмэлт хаалт хийсэн байдлыг 3.6 дугаар зургаар харуулав.

### **Зураг 3-6 Н4 маркийн лампад нэмэлт хаалт хийсэн байдал**



Энэ арга нь хэрэглэхэд хялбар, өртөг багатай.

#### **5. Их гэрлийг бүхэлд нь сольж гэрлийн тусгалыг өөрчлөх арга**

Дээр дурдсан аргууд нь өртөг зардал бага, хэрэглэхэд хялбар байдаг бол одоогийн энэ дурдаж буй арга нь зардал өндөр байхаас гадна хүний хөдөлмөр зарцуулалт илүү байдаг. Байнга, урт хугацаанд ашиглах тээврийн хэрэгслийн ойрын гэрлийн тусгалыг өөрчлөх хамгийн зөв шийдэл нь энэхүү арга байж болох юм. Учир нь дээр дурдсан аргууд нь гүйцэтгэж байгаа хувь хүний чадвар, гүйцэтгэлийн төлөв, хэрэглэж буй сэлбэг хэрэгслийн чанар, хийцээс шалтгаалахаас гадна өөрийн гэсэн онцлог дутагдалтай талтай байдагт оршино. Харин энэхүү арга нь тухайн улсын стандартын шаардлагыг хангасан их гэрлээр шууд сольж байрлуулах учраас ямар нэгэн асуудал гардаггүйгээрээ давуу юм.

Баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн их гэрлийн тусгалыг өөрчлөн, өөрийн орны нөхцөлд нийцүүлэн зохицуулах талаар манай улсад урьд өмнө хийгдэж байсан ажил байдаг. Энэ нь бас нэлээд үр дүнтэй ажил болсон. Зам тээврийн хөгжлийн яамнаас Авто тээврийн үндэсний төвтэй хамтран “Тээврийн хэрэгслийн их гэрлийн тусгалыг өөрчлөх нь” сэдвээр туршилт судалгааны ажил явуулж, гарган авсан шинэ санаачилга, инновацын бүтээгдэхүүнээрээ 2018 оны БСШУ-ы яамны дэргэдэх ШУТСЗ-д танилцуулан

гуравдугаар байрыг эзэлсэн байна. Үүнийгээ практикт нэвтрүүлэн одоогийн байдлаар 10000 гаруй тээврийн хэрэгсэлд суурилуулсан байна. Лампын тавагтай ижил хэмжээтэй тусгай бэлдэц ашиглаж их гэрлийн тусгалыг өөрчлөх аргыг ашигласан энэхүү ажлыг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын төвүүдээр суурилуулж, гэрлийн тусгал, хүчийг хяналтын төхөөрөмжөөр шалгаж, баталгаажуулсан байдаг.

Иймд зүүн гарын дүрмийн гэрлийн тусгалыг өөрчлөн баруун гарын дүрэмд нийцүүлэн өөрчлөхдөө шалгагдаж, баталгаажсан дээрх аргыг ашиглаж болох юм.

### **3.4 Тоормосны системийн эд ангийн байрлалыг шилжүүлэх**

Тоормосны систем нь автомашины хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хамгийн чухал үүрэгтэй. Баруун талдаа жолоодлогыг зүүн гар тал руу шилжүүлэхдээ онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Энэ ажиллагааг зөвхөн мэргэжлийн хүн хийж гүйцэтгэнэ.

Ихэнх автомашин үйлдвэрлэгчид автомашины кузовын зураг төслийг гаргаж үйлдвэрлэхдээ замын хөдөлгөөний зүүн болон баруун гарын дүрмийн дагуу аль алинд нь ашиглах боломжтой байдлаар төлөвлөдөг. Ингэхдээ тоормосны системийг суурилуулах суурь, бэхэлгээний боолтын нүх зэргийг баруун, зүүн талдаа адилхан гаргадаг.

Тоормосны системийн зарим эд ангийг баруун гар талаас зүүн гар тал руу шилжүүлэх зөөхдөө эдгээр бэлэн суурь, нүх, бэхэлгээний боолтын нүх зэргийг ашиглан шууд боож бэхлэх боломжтой. Нөөцөд байсан суурь, нүхийг битүүлж боосон байсан таглаа, резинэн бөглөөгөөр тоормосны эд ангийг тайлж аваад үлдсэн онгорхой үлдсэн суурь, нүхийг таглаж бэхэлнэ.

Тоормосны төв цилиндр болон бусад эд анги, зангилааг баруун гараас зүүн гар талд шилжүүлэх аргыг ихэвчлэн ашигладаг.

Тоормосны төв аппарат, хүчлүүр, ABS системийн удирдлага зэргийг шилжүүлэн байрлуулах боломжгүй тохиолдолд өөр аргыг мөн ашигладаг. Тоормосны төв аппарат, хүчлүүр, ABS системийн удирдлага зэргийг анхны өөрийн байранд нь үлдээж, тоормосны дөрөөг зүүн гар талд шилжүүлж, тэдгээрийг хөндлөн холбоосоор холбодог.

Тоормосны бүрэлдэхүүн хэсгийг найдвартай холбож, суурилуулж, ажиллагааг бүрэн хангасан байх ёстой.

## **Тоормосны төв аппаратыг шилжүүлэх**

Тээврийн хэрэгслийн зүүн гар талд байрлах тоормосны төв аппаратыг суурилуулах хэсэг, түүний том нүхийг цахилгааны багц утасны оруулга, агааржуулалтын суваг зэрэгт ашигласан байдаг. Энэ нь ихэвчлэн төв аппаратыг суурилуулсан баруун гар талынхтай адил байдаг. Иймд шууд суурилуулж болно. Хөдөлгүүрийн ажилласан болон хаягдал хий, тоос шороо, ус орохоос сэргийлж бүхээг рүү холбогдсон бүх нүх, сүвийг сайтар бөглөж битүүмжилнэ.

Төв аппарат, тоормосны дөрөөний бэхэлгээг зүүн гар талд нь анхны суурилуулсантай ижил аргаар угсарч, ижил бэхэлнэ. Жишээлбэл: бэхлэх боолтын тоо, чангалах хүч, хэмжээ зэргийг хуулбарлан ашиглана.

## **Тоормосны дөрөө**

Тоормосны дөрөөний хэлбэр нь баруун, зүүн гарын хөдөлгөөнөөс хамаарч өөр байдаг тул баруун гарын хөдөлгөөнд нийцсэнийг ашиглах хэрэгтэй. Эсвэл анхны дөрөөтэй ижил хөндлөн огтлол, хэмжээс бүхий дөрөө шинээр үйлдвэрлэх, эсвэл матаж өөрчилж болно.

Хэрэв дөрөөг зүсэж, тайрч, гагнасан бол бол найдвартай байдлыг хангахын тулд үл эвдэх туршилтыг заавал хийх шаардлагатай.

## **Тоормосны хоолой**

Тоормосны хоолойг гагнаж залгаж, сунгаж болохгүй. Шаардлагатай бол ижил шинэ ган хоолойгоор тоормосны шугамыг хийж болно. Эдгээрийн хийц, конус холболт зэрэг нь автомашины өөрийнх нь анхны эд ангитай зөв тохирч байх ёстой. Тоормосны хоолойн бүхий л уртын дагуу зохих ёсоор бэхлэгдэж, үрэгдэх, элэгдэхээс бүрэн хамгаалагдсан байх ёстой.

## **Цахилгааны холболт**

Тоормосны шингэний түвшний мэдрэгч болон бусад цахилгаан кабель утсыг сунгаж болно. Энэ нь системийн ажиллагааг бүрэн хангаж байх ёстой.

Тоормосны төв аппарат, хүчлүүр, ABS удирдлагын иж бүрдлийг тайлах, угсрах ажилбарыг тухайн тээврийн хэрэгслийн ашиглалтын гарын авлагад заасан зааварчилгааны дагуу зөвхөн мэргэжлийн хүн хийж гүйцэтгэнэ.

*Санамж:* Тоормосны шингэний шугам болон хэлхээнд ямар нэгэн гэмтэл гаргахаас сэргийл.

## **Ажиллагаа**

Тоормосны дөрөө, зангилгаа, холболтууд, хүчлүүр, төв аппарат зэрэг нь хэвийн, бүрэн ажиллах ажиллагааг хангасан байх ёстой. Төв аппаратын бүрэн явалтыг хангасан байх бөгөөд дөрөөний харьцааг өөрчилж болохгүй.

### **3.5 Хажуугийн толины тохируулгыг өөрчлөх, шинэчлэх**

Баруун болон зүүн талд байрлах хажуугийн толь нь арыг хажуу, ар талаа харах харааны талбайн шаардлагыг бүрэн хангасан байна. Суурилуулагдсан толь нь харааны талбайн хэмжээг бүрэн хангахуйц тохируулгатай байх ёстой. Хэрэв толины тохируулгын хязгаарын утга дээрх нөхцөлийг хангаж чадахгүй бол толийг зүүн гар талдаа жолооны хүрдтэй автомашиныхаар сольж тоноглоно.

### **3.6 Эдийн засгийн тооцоолол**


Зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн автомашины жолооны хүрд, гэрэлтүүлэг болон бусад механизм, зангилгаа, эд ангийг баруун гарын дүрмийн дагуу болгон шилжүүлэн байрлуулах ажлын процесс, суурилуулсны дараах хянах, шалгах ажиллагааг гүйцэтгэх техник, технологийн боломж, эдийн засгийн үр ашиг зэргийн тус бүлэгт авч үзлээ.

Тухайн автомашины хийцийн ялгаатай байдлаас шалтгаалан жолооны системийн эд ангийн байрлалыг өөрчлөх, бүхээгт байрлах хяналтын самбар, түүнд байрлах хэрэгслийг өөрчлөн шинэчлэх, их гэрлийн тусгалыг өөрчлөн тохируулах, тоормосны системийн эд ангийн байрлалыг шилжүүлэх, хажуугийн толины тохируулгыг өөрчлөх зэрэг шинэчлэх задлах, угсрах ажиллагаа нь өөр өөр байна. Үүнийгээ дагаад зарцуулах цаг хугацаа, хөдөлмөр зарцуулалт, шаардлага тусгай багаж хэрэгсэл, гүйцэтгэх технологи зэрэг харилцан адилгүй байхаар гадна өртөг ч мөн адил ялгаатай байна.

Иймд энэхүү бүлэгт дурдагдсан систем, механизм, эд ангийг өөрчлөн солихтой холбогдсон технологи, ажилбарыг гүйцэтгэхдээ тухайн автомашины үйлдвэрлэгчээс зөвлөсөн засварын гарын авлагыг баримтлах нь зүйтэй.

Зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон шилжүүлэн байрлуулах технологийн процессыг ерөнхий байдлаар авч, доорх бүдүүвчээр үзүүллээ.

### Зураг 3-7 LHD-ийг RHD болгон хувиргах технологи





**Шаардлагатай тоног төхөөрөмж:** Автомашины бүхээгийн дотор талын хяналтын самбар, түүнд байрлах мэдээлэх хэрэгсэл, хажуугийн толины харах өнцөг, авцуулах холбоо, хурдасгах, тоормосны дөрөө бусад цахилгаан тоноглол зэргийг өөрчлөн байрлуулж угсрахад нарийн тохируулга гүйцэтгэх ажиллагаа, тоног төхөөрөмж шаардлагагүй.

Жолооны системийн механизм, эд ангийн байрлалыг өөрчлөн угсарсны дараа дугуйн тавилтын өнцгүүдийг өндөр нарийвчлалтай хэмжих тоног төхөөрөмжийг ашиглан шалгана. Манай улсын авто засварын газруудын түгээмэл хэрэглэж буй дугуй тавилтын өнцгийг шалгах төхөөрөмж (Launch X681 болон X631, Heshbon 303 гэх мэт)-үүд нь дугуйн хумайлт, дэрвийлт, налалт, их бага залагдалтын өнцөг болон тэнхлэг хоорондын өнцгүүдийн өндөр нарийвчлалтай хэмждэг. Иймд эдгээр төхөөрөмжийг ашиглан шалгах, тохируулах ажлыг бүрэн гүйцэтгэх боломжтой.

Их гэрлийн тусгалыг өөрчлөх, тохируулах явцдаа авто засварын газрууд болон авто тээврийн хэрэгслийн хяналт, үзлэгийн төвүүдэд хэрэглэгддэг их гэрлийн тусгал, гэрэлтүүлэх хүчийг шалгах төхөөрөмжөөр шалгаж, тохируулж болно.

Одоогийн байдлаар тоормосны системийн механизм, эд ангийн байрлалыг шилжүүлсний тус системийн ажиллагааг шалгах, үнэлэх тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж авто засварын газруудад дутагдалтай байна. Гэвч энэ төрлийн ажлыг гүйцэтгэх боломжтой тоормосны стенд нь дэлхийн зах зээлд дунджаар 20000 ам. долларын үнэтэй худалдаалагдаж байна.

Харин авто тээврийн хэрэгслийн хяналт, үзлэгийн төвүүдэд хэрэглэж байгаа тоормосны төхөөрөмжийг ашиглан ажиллагааг шалгах, үнэлэх боломжтой юм.

Дээрх байдлаас үзэхэд зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн автомашины жолооны хүрд, гэрэлтүүлэг болон бусад механизм, зангилгаа, эд ангийг баруун гарын дүрмийн дагуу болгон шилжүүлэн байрлуулах ажлын процесс, суурилуулсны дараах хянах, шалгах ажиллагааг гүйцэтгэхэд багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техникийн боломж, хүрэлцээ хангалттай түвшинд байна гэж дүгнэж байна.

**Боловсон хүчний хангамж:** Өнөөгийн байдлаар зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон өөрчилж, гүйцэтгэж байсан ажлын дадлага, туршлагатай инженер техникийн ажилтан цөөн байгаа боловч богино хугацаанд мэргэшүүлэн дадлагажуулах боломжтой юм.





### Эдийн засгийн үр ашгийн тооцоо

Зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон өөрчлөх нь эдийн засгийн үр ашигтай эсэхийг тодруулахдаа 2013 оноос 2016 оны хооронд үйлдвэрлэгдсэн Тоёота Харриер болон Lexus RX загварын автомашиныг жишээ болгон авлаа. Эдгээр автомашинуудыг сонгон авахдаа:

- Манай улсад хэрэглэгдэх тухайн загварын автомашины тоо,
- Автомашин эзэмшигчдийн сэтгэгдэл, төлбөрийн чадвартай байдал,
- Тухайн автомашинуудын бүхээг, систем, механизм, эд ангийн төсөөтэй, хоорондоо тохирох байдал зэргийг харгалзсан.




Сонгон авсан автомашинуудын одоогийн зах зээлийн бодит үнийг тодорхойлох, харьцуулахдаа автомашиныг худалдах худалдааны сайтуудаас хайж, доорх зургаар үзүүлэв.

### Зураг 3-8 Тоёота Харриер автомашины үнэ<sup>60</sup>

	<b>Toyota Harrier, 2016/2019</b> Гэр бүлийн Автомат Өнөөдөр 17:14, Улаанбаатар Toyota » Harrier	53 сая ₮	☆
	<b>Toyota Harrier, 2015/2021</b> Жийп Автомат 2022-11-15 20:09, Улаанбаатар Toyota » Harrier	54 сая ₮ 69 сая ₮	☆
	<b>Toyota Harrier, 2014/2020</b> Жийп Автомат 2022-11-04 14:30, Улаанбаатар Toyota » Harrier	55 сая ₮ 62 сая ₮	☆
	<b>Toyota Harrier, 2015/2020</b>	55 сая ₮	☆

<sup>60</sup> [https://www.unegui.mn/avto-mashin/-avtomashin-zarna/toyota/harrier/year\\_max---2016/year\\_min---2013/?ordering=cheapest3](https://www.unegui.mn/avto-mashin/-avtomashin-zarna/toyota/harrier/year_max---2016/year_min---2013/?ordering=cheapest3)

### Зураг 3-9 Lexus RX автомашины үнэ<sup>61</sup>

	<b>Lexus RX, 2016/2020</b> Жийп Автомат 2022-11-11 17:25, Улаанбаатар Lexus » RX	103 сая ₮ <del>100 сая ₮</del>	☆
	<b>Lexus RX, 2013/2022</b> Жийп Автомат 2022-11-05 11:49, Улаанбаатар Lexus » RX	96 сая ₮	☆
	<b>Lexus RX, 2015/2022</b> Жийп Автомат 2022-11-15 19:23, Улаанбаатар Lexus » RX	95 сая ₮	☆

Эндээс үзэхэд Тоёота Нарриер маркийн автомашин дундаж үнэ 55 сая төгрөг бол Lexus RX автомашин нь дунджаар 98 сая төгрөгийн үнэтэй байна.

Одоо зүүн гарын дүрмийн дагуу үйлдвэрлэгдсэн Тоёота Нарриер автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон өөрчлөхөд гарах сэлбэгийн өртгийг тооцож үзье.

### Хүснэгт 3-1 Тоёота Нарриер автомашиныг баруун гарын дүрмийн дагуу болгон өөрчлөхөд шаардлагатай сэлбэгийн өртөг<sup>62</sup>




№	Сэлбэгийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Их гэрэл	2	800,000	1,600,000
2	Хажуугийн толь	2	600,000	1,200,000
3	Хянах самбар (иж бүрдэл)	1	-	-
4	Хурдны хайрцгийн сэлгэн залгах хөшүүрэг	1	2,800,000	2,800,000
5	Жолооны цахилгаан хүчлүүртэй (иж бүрдэл)	1	2,800,000	2,800,000
6	Жолооны аппарат (иж бүрдэл)	1	1,800,000	1,800,000
7	Тоормосны дөрөө	1	120,000	120,000
8	Хурдасгах дөрөө	1	120,000	120,000
9	Дулаацуулгын хоолой (иж бүрдэл)	1	250,000	250,000
<b>Нийт үнэ</b>				<b>10,690,000</b>

<sup>61</sup> [https://www.unegui.mn/avto-mashin/-avtomashin-zarna/lexus/rx/ruli---zv/year\\_max---2016/year\\_min--2013/?ordering=expensive](https://www.unegui.mn/avto-mashin/-avtomashin-zarna/lexus/rx/ruli---zv/year_max---2016/year_min--2013/?ordering=expensive)

<sup>62</sup> Хянах самбарын иж бүрдлийг худалдаж үнийг хайгаад олдоогүй

Дээрх сэлбэгийн өртөг дээр шилжүүлэн байрлуулах хөдөлмөрийн хөлс, хянан шалгаж зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын үйлчилгээний хөлс нэмэгдэх болно.

**Хүснэгт 3-2 Тоёота Нарриер автомашины сэлбэгийн үнэ, зураг**

№	Сэлбэгийн нэр	Зураг
1	Жолооны цахилгаан хүчлүүртэй иж бүрдэл	 <p>4520A58010 Genuine Toyota Column Sub-assy Electric Power Steering 4520a-58010</p> <p>★★★★★ Be the first to <a href="#">write a review</a>   <a href="#">About this product</a></p> <p>Your pick: \$796.30   Brand new: \$734.84</p> <p>Your pick: <b>\$644.55</b> + \$151.75 Shipping</p> <p>Get it by Thu, Dec 1 - Mon, Dec 12 from Sharjah, United Arab Emirates</p> <p>• New condition • 30 day returns - Buyer pays return shipping</p> <p>*Condition: OEM 100% GENUINE NEW PART, East Asia and Middle East -*</p> <p><a href="#">See details</a></p> <p>Sold by <a href="#">partscoug (14509)</a> 99.2% Positive feedback <a href="#">Contact seller</a></p>
2	Жолооны аппаратны иж бүрдлийн үнэ	 <p>Toyota OEM Genuine Gear Assy Steering 45510-42210</p> <p>Condition: New Sale ends in: 4d 16h</p> <p>Price: <b>US \$512.97</b> Was US \$539.97 Save US \$27.00 (5% off)</p> <p><a href="#">\$42.74 for 12 months with PayPal Credit*</a></p> <p>Best Offer: <a href="#">Make offer</a></p> <p><a href="#">Add to Watchlist</a></p> <p><input type="checkbox"/> 1-year accident protection plan from Allstate - \$109.99</p>
3	Их гэрлийн үнэ	 <p>TOYOTA GENUINE 8111047030 HEADLAMP ASSY, RH 81110-47030</p> <p>Genuine OEM Toyota Lexus Parts, Fast Shipping.</p> <p>Condition: New Compatibility: <a href="#">See compatible vehicles</a></p> <p>Quantity: <input type="text" value="1"/> available / 1 sold</p> <p>Price: <b>US \$294.06</b> <a href="#">No Interest if paid in full in 6 mo on \$29+*</a></p> <p><a href="#">Add to Watchlist</a></p> <p><input type="checkbox"/> 1-year accident protection plan from Allstate - \$35.99</p> <p><b>Last item available</b></p>

Мөн тухайн автомашин жолооны аппарат, цахилгаан хүчлүүр, их гэрэл зэрэг техникийн байдал нь хэвийн хуучин сэлбэгийг худалдан борлуулж, зарцуулсан өртгийн тодорхой хэсгийг нөхөж болно.

### Хүснэгт 3-3 Тоёота Нарриер автомашины нийт зардлын тооцоо

Зардлууд		Ажлын хоног	Нийт зардал
1	Сэлбэг	20 хоног	11,000,000-12,000,000
2	Ажлын хөлс	5 хоног	4,000,000
3	Нийт	25 хоног	15,000,000-16,000,000

Нийт сэлбэг хэрэгсэл дундаас хянах самбар (иж бүрдэл)-ийн олдоц маш муу байна. Иймд хуучин хянах самбар авах, шинээр захиалж хийлгүүлэх боломжтой байна. Иймд нийт сэлбэгийн зардал 11-12 сая төгрөг болж байна. Хэрвээ сэлбэгийг эхнээс нь захиалж авсан тохиолдолд нийт 25 хоногт, нийт 15-16 сая төгрөгийн зардалтай байна.

### 3.7 Бүлгийн дүгнэлт

- ❖ Энэхүү бүлэгт дурдагдсан аливаа ажил нь техникийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдалтай шууд холбоотой. Иймд угсрах, тохируулах, хянах, шалгах болон бусад технологи ажиллагааг гүйцэтгэхдээ зөвлөсөн технологийг баримтлахгүй байх, ажлыг хялбарчлахыг хориглоно.
- ❖ Автомашины төрөл, хийцийн онцлог ялгаатай байдал зэргээс хамааран жолоодлогыг зүүн гарын дүрмээс баруун гар талын дүрмийн дагуу шилжүүлэх ажил нь тус бүрдээ ялгаатай байх тул тухайн загварт тохирох үйлдвэрлэгчээс санал болгосон технологи, технологийн картыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.
- ❖ Жолооны системийн эд ангийн байрлалыг өөрчилсний дараа тухайн автомашины эд ангийн бэхэлгээ, хэвийн ажиллагаа, дугуй тавилтын өнцөг зэрэг нь уг автомашины үйлдвэрлэгчээс заасан стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий байгууллага шалгаж баталгаажуулна.
- ❖ Их гэрлийн эд ангийг өөрчлөн тусгалыг баруун гар талын дүрмийн дагуу шилжүүлэн өөрчилсний дараа гэрлийн тусгал нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий байгууллага шалгаж, баталгаажуулна.

- ❖ Бүхээгийн доторх эд анги, жолооны хүрд, тоормосны дөрөөний байрлал, хянах, шалгах хэрэгсэл зэргийн хэвийн ажиллагаа, хажуугийн толь зэрэг нь жолоочийн эргономик үзүүлэлтийг хангаж буй байдал, хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй байгаа эсэхийг эрх бүхий байгууллага шалгаж баталгаажуулна.
- ❖ Эндээс дүгнэхэд автомашины жолоодлогыг зүүн гарын дүрмээс баруун гар талын дүрмийн дагуу шилжүүлэн техникийн өөрчлөлт гүйцэтгэх ажлын явцыг удирдан зохион байгуулах, хянах нарийн мэргэшсэн мэргэжилтэн, үзлэг, хяналтыг гүйцэтгэж, зөвшөөрөл олгох эрх бүхий мэргэжлийн байгууллага шаардлагатай байна.

#### 4 САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

---

- 2021 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн 22,482 зам тээврийн ослын 97.8% нь жолоочийн буруугаас болжээ. Мөн хүний амь нас хохирсон зам тээврийн ослын 26.6% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 28.2% нь анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, 18.5% нь хурд хэтрүүлснээс шалтгаалж, онхолдох хэлбэрээр 47.6% нь гарч хүний амь нас хохирчээ. Эндээс нэгтгэн дүгнэвэл тээврийн хэрэгслийн жолооны хүрднээс гадна жолоочийн хариуцлагатай байдал, зөв дадал хэвшлийг бий болгох, хуулийн чанга зохицуулалт нэн шаардлагатай байна.
- Судалгааны ажилд тусгагдсан эрх зүйн хэм хэмжээнүүдийг судлан буй сэдвийн хүрээнд авч үзэж, үр дүнг нэгтгэн дүгнэвэл дор дурдсан нөхцөл байдал үүссэн болно.
- Тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн талд шилжүүлэн зорчих хөдөлгөөний эсрэг талд гаргах эрх зүйн зохицуулалт бий болбол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын зам, тээврийн салбарын конвенцуудтай зөрчилдөхөөргүй байна.
- Нэгэнт иргэдийн хэрэглээнд нэвтэрсэн баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг зүүн талд шилжүүлэх технологийг ашиглахад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай. Тодруулбал, Иргэдийн хувийн тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх хөндөгдөхөөр байна. Мөн тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчилж, түүнд хязгаарлалт тогтоовол Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан чөлөөтэй зорчих эрхийг хөндөх эрсдэл үүснэ. Иймд Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс хүний болон иргэний үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлаж болохоор заасан тул Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах хэрэгцээ зайлшгүй үүсэхээр байна.
- Хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон түүний харьяа байгууллагуудаас нэгдсэн зохион байгуулалт хийх үүднээс Захиргааны Ерөнхий хуулийн 59 дүгээр



зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан захиргааны хэм хэмжээний акт батлах бүрэн эрхийг хуулиар олгох шаардлагатай.

- Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн эд ангийг үндэсний стандартад нийцүүлэн сольж өөрчлөх талаарх хууль, эрх зүйн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд импортоор оруулж ирсэн баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдийг зүүнд шилжүүлэх хугацаа, хяналт тавих төрийн захиргааны байгууллагад бүрэн эрхэд өөрчлөлт оруулах;
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Захиргааны Ерөнхий хуульд зааснаар жолооны хүрдийг өөрчлөхөд тавигдах шаардлага бүхий журам батлан мөрдүүлэх эрхийг Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэхээр тусгах;

Тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчилж, нэгдсэн зохицуулалт бий болгосон улсуудын туршлагыг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Судлагдсан орнуудын хувьд тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг замын хөдөлгөөний батлагдсан талын эсрэг чиглэлд шилжүүлэхийн тулд тухайн улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай тохиолдолд холбогдох журам, стандартуудыг шинээр баталсан байна.
- Замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдлыг хангах үндэслэлээр замын хөдөлгөөний батлагдсан талын эсрэг чиглэлд жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн тоог бууруулах, жолооны хүрдний байршлыг өөрчлөхийн тулд тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хязгаарлалтыг зохистой байдлаар тогтоох нь зүйтэй байна.
- Судлагдсан орнуудын хувьд хууль, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл, зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл гэх нэр томъёог нэгдсэн ойлголтоор хэрэглэж, батлагдсан талын эсрэг чиглэлд жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг ямар тохиолдолд бүртгэх тухай тусгайлан

жагсааж, жолооны хүрдний байршлыг өөрчилсөн тохиолдолд холбогдох техникийн шаардлагад нийцүүлсэн байх тухай зохицуулж өгчээ.

- Жолооны хүрдний байршлаас шалтгаалж тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хязгаарлалт тогтоох нь олон этгээдийн эрх ашгийг хөндөж байх тул холбогдох хууль, тогтоомжийн өөрчлөлт, журам, стандартыг боловсруулах ажиллагаанд тэдгээрийг оролцуулж, холбогдох санал, дүгнэлтийг тусгаснаар үүсэж болох ирээдүйд үүсэж болох хүндрэлээс сэргийлэх боломжтойг практик харуулж байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хууль, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл, зүүн гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл гэх нэр томъёог тодорхойлох, баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзаж, хөдөлгөөнд оролцуулахыг хориглох, тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байршлыг өөрчлөх шаардлага болон ямар тохиолдолд баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг бүртгэж, хөдөлгөөнд оролцуулахыг зөвшөөрөх тухай зохицуулалтыг тээврийн хэрэгслийн онцлогт нийцүүлж боловсруулах;
- Жолооны хүрдний байршлыг өөрчилсөн тохиолдолд ямар техникийн шаардлагад хангах тухай үндэслэлийг техникийн шинжлэх ухаанд суурилж, аюулгүй байдлыг нийцүүлэх боловсруулах, тэрхүү өөрчлөлтийг хууль эрх зүйн хүрээнд хэн гүйцэтгэх, хэн, хэрхэн шалгах эрх хэмжээтэй байх тухай нэгдсэн зохицуулалт бий болгох;
- Жолооны хүрдний байршлаас шалтгаалж тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах, жолооны хүрдний байршилд өөрчлөлт оруулах холбогдох зохицуулалтыг боловсруулахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийг оролцуулах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, холбогдох саналыг тусгах;

## Ном зүйн жагсаалт

### 1. Хууль тогтоомж

- Авто тээврийн тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- Замын хөдөлгөөний дүрэм

### 2. Ном сурах бичиг, гарын авлага

- Авто тээврийн ажилтны гарын авлага Д.Ёндонсүрэн, А.Цэцэгмаа, Т. Батцэцэг, Ж. Мөнхтөр
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал А.Энхболд
- Замын хөдөлгөөний тухай конвенц
- Улаанбаатар хотын түүхэн хураангуй, УБ, 1994 он
- Монгол улсын зам тээвэр, УБ, 2005 он
- Судалгаа шинжилгээний арга зүй Ч.Авдай, Д. Энхтуяа
- Судалгааны арга зүй, УБ, 2001, Чимэдлхам,Б.Жадамба
- Замын хөдөлгөөний осолгүй байдал, автотээврийн экологи, Д. Дүгэрээ
- Улаанбаатар хотын түүхэн хураангуй, УБ, 1994
- Монгол Улсын зам тээвэр, УБ, 2005

### 3. Интэрнэт

- <https://legalinfo.mn/mn>
- <https://www.unesco.org/en>
- <http://trafficpolice.gov.mn/>
- <https://mrttd.gov.mn/>

## ХАВСРАЛТ

### 4.1 Тээврийн хэрэгсэл, автомашины тоо

Манай улсад авто тээврийн анхны хууль батлагдах үед 70 мянга хүрэхгүй тээврийн хэрэгсэлтэй байсан бол 2021 оны эцсийн байдлаар Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 1,243,445-д хүрчээ. Эндээс 668,397 нь Улаанбаатар хотод байна. Харин автомашины тоо 1,101,769-д хүрсэн бөгөөд 2009-2013 онуудад өндөр өсөлттэй байсан байна.

#### Хүснэгт 4-1 Тээврийн хэрэгслийн тоо, автомашины тоо

Он	Тээврийн хэрэгслийн тоо	Автомашины тоо	Автомашины өсөлтийн хувь
2007	200,228	161,989	
2008	216,422	176,897	9%
2009	266,430	224,909	27%
2010	285,397	254,486	13%
2011	349,465	312,542	23%
2012	554,577	504,423	61%
2013	675,064	620,661	23%
2014	734,479	674,869	9%
2015	789,706	720,766	7%
2016	841,537	766,019	6%
2017	900,127	815,009	6%
2018	970,080	871,350	7%
2019	1,043,028	934,510	7%
2020	1,126,776	1,004,800	8%
2021	1,243,445	1,101,769	10%

Нийт тээврийн хэрэгслийн 63 хувь буюу 782,210 нь суудлын автомашин, автобус 34,211, ачааны автомашин 226,364, тусгай зориулалтын автомашин 16,228, зүтгүүр 38,523, механизм 16,596, чиргүүл 53,290, мотоцикл 71,790 тус тус бүртгэгдсэн байна.

#### Хүснэгт 4-2 Зам тээврийн ослын шалтгаанууд

Ослын тохиолдлууд	Нийт		Улаанбаатар	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Зай тохируулаагүй	11,786	48%	11,586	54%
Уулзвар нэвтрэх	4,220	17%	3,988	19%
Эгнээ байр	2,964	12%	2,855	13%
Ухрах	1,630	7%	1,487	7%
Хурд хэтрүүлсэн	989	4%	583	3%
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	978	4%	514	2%

Анхаарал болгоомжгүй	675	3%	11	0.1%
Зогсоох арга хэмжээ аваагүй	540	2%	49	0.2%
Эсрэг урсгал	209	1%	91	0.4%
Гүйцэж түрүүлэх	184	1%	36	0.2%
Бусад	156	1%	14	0.1%
Гэрлэн дохио	142	1%	115	0.5%
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	131	1%	23	0.1%
Эргэх үйлдэл	75	0.3%	19	0.1%
Хүн ба тээврийн журам зөрчсөн	62	0.3%	36	0.2%
<b>Нийт</b>	<b>24741</b>	<b>100%</b>	<b>21407</b>	<b>100%</b>

### Хүснэгт 4-3 Авто ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоо

Он	Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
	Нийт	Улаанбаатар	Орон нутаг	Нийт	Улаанбаатар	Орон нутаг
2010	320	127	193	933	564	369
2011	362	103	259	1093	622	471
2012	369	114	255	1077	608	469
2013	423	117	306	1282	726	556
2014	501	138	363	1460	726	734
2015	429	112	317	1382	749	633
2016	399	89	310	1247	681	566
2017	392	74	318	1135	559	576
2018	325	91	234	998	464	534
2019	319	85	234	1072	561	511
2020	264	77	187	784	376	408
2021	383	116	267	2475	1501	974

#### 4.2 Авто тээврийн салбарын дүрэм, журмууд

Өнөөдөр дэлхийн нийт хүн амын 65% нь баруун гар талын замын хөдөлгөөний дүрэмтэй, 35% нь зүүн гар талын дүрэмтэй. Баруун гарын замын хөдөлгөөний дүрэм нь хуурай газрын тивд давамгайлж дэлхийн ихэнх арлын орон үндэстнүүд зүүн талдаа жолооддог.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хуулиар нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцууд нь эрх зүйн хүчин чадлын хувьд хуулийн адил хүчин төгөлдөр үйлчлэхээр хуульчилсан. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон

*тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус зохицуулсан байдаг.*

Манай улсын нэгдэн орсон Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай Вений Конвенц<sup>63</sup>-д замын баруун, зүүн аль ч талын хөдөлгөөнтэй улс оронд нийцэх байдлаар боловсруулагдсан эрх зүйн акт тул “хөдөлгөөний батлагдсан тал” гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэг байна.

Замын хөдөлгөөний тухай Конвенцын 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “*Хоёр улсын хоорондох хилийг дамжин өнгөрөхөд зориулагдсан буюу тусгай байдлаар ашиглагддаг замаас бусад бүх зам нь тухайн улсын хувьд хөдөлгөөний ижил чигтэй байна”* гэж заасан нь улс орон бүр өөрийн нийт нутаг дэвсгэртээ замын хөдөлгөөний тогтсон нэг талыг баримтлах олон улсын эрх зүйн хэм хэмжээний шаардлага болно. Тухайлбал, замын хөдөлгөөнд оролцогчдын хувьд хөдөлгөөний зохицуулалт нь хууль тогтоомжоор шийдэгдэхээс гадна хөдөлгөөний хэвшмэл байдал чухал байр суурийг эзэлдэг байна. Ялангуяа жолооч нарын хувьд тээврийн хэрэгслүүдийн зөрж өнгөрөх байрлал болон уулзвараар баруун, зүүн гар тийш эргэхдээ хөндлөн замын зөв урсгалыг эзлэх зэрэг эрх зүйн зохицуулалтаас илүүтэйгээр сэтгэхүйн тогтсон хэвшмэл үйлдэл дээр хийгддэг учир тухайн улсын хувьд замын хөдөлгөөний ижил чигтэй байх нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Улс орон бүр Конвенцын дээрх заалтыг мөрдлөг болгон замын хөдөлгөөнийхөө батлагдсан талыг өөрийн улсын нийт нутаг дэвсгэрийг хамааруулан чандлан тогтоодог төдийгүй байнга харилцаатай бүс нутаг, хил залгаа хөрш орнуудын хэмжээнд ижил мөрдөхийг эрхэмлэдэг. Гэхдээ түүхэн уламжлал, ёс заншил зэргээс хамаарч зарим цөөн улс орны харьяа нутаг дэвсгэрүүд, тухайлбал АНУ-ын Виржиний арлуудын хувьд замын хөдөлгөөний эсрэг талыг баримтлан мөрддөг тохиолдол бий.

Замын хөдөлгөөний батлагдсан талдаа нийцүүлэн тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг технологийн шийдэл, бодлогын түвшинд авч үзэж зүүн талд шилжүүлэхэд одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомж болон шаардлагатай эрх зүйн зохицуулалтын талаарх санал, дүгнэлт гаргахад энэхүү хэсгийн гол зорилго болно. Манай улс зам тээврийн салбарын хууль, түүнд нийцүүлэн гаргасан

---

<sup>63</sup> Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн “Конвенцийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орох тухай” хуулиар соёрхон баталсан.

журам, стандартуудын хүрээнд тээврийн хэрэгслийн жолооны хүрдийн байршлыг тогтоосон байдаг байна.

Судлан буй асуудлын хүрээнд манай улсад өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид хамаарах эрх зүйн хэд хэдэн зохицуулалт байдаг. Үүнд:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт *“Монгол Улсад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгийн баруун гар талаар явуулна”* гэж;
2. Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт *“Нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зориулалтын, стандартад нийцсэн, зүүн гар талдаа жолооны хүрдтэй, зорчигчийг баруун гар тал руугаа буулгаж, суулгах нөхцөлийг хангасан автотээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ”* гэж тус тус зохицуулсан байна.

Авто тээврийн салбарын холбогдолтой дараах дүрэм, журмууд үйлчилж байна.

#### **Хүснэгт 4-4 Авто тээврийн салбарын дүрэм, журмууд**

№	Нэр	Дугаар	Батлагдсан огноо
1	Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам	A/86	2020-09-08
2	Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам	A/154	2020-08-17
3	3 дугаар хавсралт- ИНД-43 “Техник үйлчилгээний ерөнхий дүрэм”	111	2010
4	Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам	59	2012-10-29
5	Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, ажлын тусгай зөвшөөрөл олгох журам	131	2018-06-18
6	Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам, гэрчилгээний загвар/ ЗТБХБС-ын 2011 оны 278 дугаар тушаалаар өөрчлөлт орсон	128	2010-04-29
7	Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах	232	2013-10-21
8	Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам	296	2011-10-28



9	Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам	A/154	2020-08-17
10	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам.	4/62	2018-02-12
11	Норм дүрэм батлах тухай-"Авто замын уур амьсгал, гео техникийн нөхцөл" БНБД/АЗУАГ	2.01.01-2004/ 22	2004-11-15
12	Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам	A/116	2021-08-20
13	Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхийн загвар батлах тухай /Авто тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр/	161/229	2010-05-07

Авто тээврийн салбарт мөрдөгдөж буй стандартуудаас баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн гар талд шилжүүлэхтэй холбоотой хууль эрхзүйн холбогдох заалтуудыг түүвэрлэн харуулж байна. Үүнд:

#### **Хүснэгт 4-5 Хууль эрхзүйн холбогдох заалтууд**

№	Хууль, дүрэм	Батлагдсан огноо	Заалтууд
1	ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр	<p>21 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, түүний хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, импортлоход тавих шаардлага</p> <p>21.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор тус улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд шинжлэх ухааны холбогдох байгууллагын дүгнэлтээр баталгаажсан байна.</p> <p>21.2.Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх</p>

			<p>бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна.</p> <p>21.3.Гадаад улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.</p> <p>21.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно.</p> <p>21.5.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд анги, нэмэлт тоног төхөөрөмжийн хийцийг өөрчилсөн тохиолдолд техникийн хяналтын үзлэг, оношилгоог давтан хийлгэж гэрчилгээ авна.</p> <p>4.4.Монгол Улсад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын зорчих хэсгийн баруун гар талаар явуулна.</p>
2	МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ	Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолын хавсралт	<p>13.1. Жолооч гүйцэж түрүүлэхийн өмнө хөдөлгөөний эрчим, хурд, тээврийн хэрэгсэл болон тээж яваа ачааны онцлог, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан, уг үйлдлийг гүйцэтгэхэд аюул үүсгэхгүй, бусдын хөдөлгөөнд саад учруулахгүй байх, мөн хүрэлцэхүйц хэмжээний зай байгаа эсэхийг анхаарч мэдсэн байвал зохино.</p> <p>13.6. Нэг эгнээнд урд яваа тээврийн хэрэгсэл зүүн гар тийш дохио өгч байгаа үед түүний зүүн гар талаар, баруун гар тийш дохио өгч байгаа үед түүний баруун гар талаар орж гүйцэхийг хориглоно.</p> <p>18.1. Харанхуй үед болон үзэгдэлт хангалтгүй нөхцөлд, мөн хонгил дотор жолооч тээврийн хэрэгслийн гадна талын гэрлийг дараах байдлаар асааж явна:  а/ замын гэрэлтүүлэггүй хэсэгт холын буюу ойрын гэрлийг асаана;  б/ замын гэрэлтүүлэгтэй хэсэгт ойрын гэрлийг асаана;</p>

			<p>в/ чиргүүлтэй яваа үед түүний оврын гэрлийг асаана.</p> <p>18.2. Дараах тохиолдолд холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлнэ:  а/ өөдөөс яваа тээврийн хэрэгсэл хүртэл 150 м-ээс багагүй зайд;  б/ өөдөөс яваа тээврийн хэрэгслийн жолооч гэрэл шилжүүлэх дохио өгвөл зайн хэмжээг үл харгалзан;  в/ бусад жолоочийн нүдийг гялбуулж болзошгүй тохиолдолд.</p> <p>18.8. Тээврийн хэрэгсэлд өдрийн цагаар асааж явахад зориулан үйлдвэрээс тоногдсон гэрлийг жолооч өдрийн цагт хөдөлгөөнд оролцохдоо асааж болно.</p>														
<p>ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ЭВДРЭЛ, ГЭМТЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ</p>		<p>Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 4 дүгээр хавсралт</p>	<p>1.1. Ажлын тоормосны идэвхжил нь MNS 4598 стандартад заасан үзүүлэлтийг хангаж чадахгүй байх;</p> <p>1.2. Шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсан;</p> <p>1.3. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн даралт хэмжүүр ажиллахгүй болсон;</p> <p>1.4. Хийн буюу хий-шингэн дамжуулгатай тоормосны системийн битүүмж алдагдсанаас (хөдөлгүүрийг унтраасны дараа) хийн бүрэн даралтын хэмжээ 15 минутын хугацаанд 0.05 МПа-аар буюу түүнээс илүү хэмжээгээр буурсан;</p> <p>1.6. Тоормосны системийн эд ангиудын хийцийг өөрчилсөн.</p> <p>2.1. Жолооны механизмын эд ангиудын бэхэлгээ эвдэрсэн, холбоосны сул хөдөлгөөн ихэссэн;</p> <p>2.2. Үйлдвэрээс хийгдсэн хүчлүүр (мотоциклын хувьд зөөллүүр) ажиллахгүй буюу байхгүй болсон;</p> <p>2.3. Жолооны хүрдний сул эргэлтийн хэмжээ дор дурдсанаас илүү болсон:</p> <table border="1" data-bbox="715 1630 1283 1765"> <thead> <tr> <th colspan="2">Тээврийн хэрэгслийн төрөл</th> <th>Жолооны хүрдний сул эргэлт (градус)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="2">Суудлын автомашин, бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин</td> <td>5</td> </tr> <tr> <td colspan="2">Автобус, троллейбус</td> <td>10</td> </tr> <tr> <td rowspan="2">Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин</td> <td>шингэн хүчлүүртэй</td> <td>10</td> </tr> <tr> <td>шингэн хүчлүүргүй</td> <td>5</td> </tr> </tbody> </table> <p>2.4. Жолооны механизмын эд ангиудын хийцийг өөрчилсөн.</p> <p>4.5. Хурдны хайрцгийн араан дамжуулга хүндрэлтэй залгагддаг, өөрөө салдаг;</p> <p>5.3. Гэрлийн бүрхүүл бохирдсон, хагарч цөмөрсөн, байхгүй болсон буюу бүрхүүл</p>	Тээврийн хэрэгслийн төрөл		Жолооны хүрдний сул эргэлт (градус)	Суудлын автомашин, бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин		5	Автобус, троллейбус		10	Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин	шингэн хүчлүүртэй	10	шингэн хүчлүүргүй	5
Тээврийн хэрэгслийн төрөл		Жолооны хүрдний сул эргэлт (градус)															
Суудлын автомашин, бүх жин нь 3.5 тонноос илүүгүй ачааны автомашин		5															
Автобус, троллейбус		10															
Бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин	шингэн хүчлүүртэй	10															
	шингэн хүчлүүргүй	5															

			дээр өнгөт хальс наасан, гэрэл нь асахгүй, бүдэг асдаг болсон;
			5.4. Үйлдвэрээс тавьсан гэрэл ойлгуур бохирдсон буюу байхгүй болсон;
			6.1. Хурд хэмжүүр ажиллахгүй болсон;
			6.9. Үйлдвэрээс тавьсан хамгаалах бүс, суудлын дэр байхгүй буюу ашиглалтын шаардлага хангахгүй болсон;

Жолооны хүрдний талаар хэрхэн зохицуулсан зохицуулалтыг судлан, зохицуулалтыг түүвэрлэн, энэхүү хэм хэмжээнд дүгнэлт хийж байна. Баруун гар талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдийг зүүн гар талд шилжүүлэхэд түүвэрлэсэн хэм хэмжээнээс ямар зохицуулалт хэрхэн өөрчлөгдөж болох талаар дүгнэлт зөвлөмжийг гаргаж байна.

#### **4.3 Тээврийн хэрэгслийн эд ангийг өөрчлөх, солиход шаардагдах хөдөлмөрийн болон ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа**

### **ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭД АНГИЙГ ӨӨРЧЛӨХ, СОЛИХОД ШААРДАГДАХ ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН АЖЛЫН БАЙРНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

#### **Нэг. Зорилго болон хамрах хүрээ**

- 1.1. Энэ зааврын зорилго нь техник, тээврийн хэрэгслийн эд ангийг өөрчлөх, солих үйлчилгээг хийж гүйцэтгэх үеийн механик болон багаж хэрэгсэл ашиглах үеийн аюулгүй ажиллагааг хангахад оршино.
- 1.2. Энэ зааврыг судалгааны ажлын хүрээнд боловсруулсан бөгөөд байгууллагууд өөрийн онцлогт тохируулан ашиглах боломжтой.
- 1.3. Энэхүү зааварт дараах нэр томъёонуудыг ашигласан. Үүнд:

#### **Хоёр. Ерөнхий шаардлага**

- 2.1. Ажилтан нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна.
  - 2.1.1. Ээлжийн ажил эхлэхийн өмнө ажлын наряд, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, танилцан гарын үсэг зурж баталгаажуулна.
  - 2.1.2. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн ашиглаж ажилд гарна.

- 2.1.3. Ажлын байрны эмх цэгцийг чандлан сахиж, саад болж буй бүх зүйлийг зайлуулна.

### **Гурав. Аюулгүй ажиллагаа**

- 3.1. Тээврийн хэрэгслийг тэгш гадаргууд байрлуулж автомашин хөдлөхгүй байх бүхий л арга хэмжээг авч ажиллах. Ингэхдээ дараах зүйлсийг анхаарч шалгана.
- Гар тормоз
  - Дугуйн ивүүр
- 3.2. Засварын ажилд шаардлагатай зориулалтын, тохирсон багаж хэрэгслийг бэлдсэн байх
- 3.3. Тээврийн хэрэгслийг тэгш гадаргуу дээр байрлуулж, тухайн техникийн даацад тохирсон зориулалтын домакрат сонгоно.
- 3.4. Хөдөлгөөнт машин механизмын жишиг тооцож, зориулалтын даацад тохирсон тулгуур ашиглах
- 3.5. Хөдөлгөөнт машин механизмыг тэгш гадаргууд байрлуулна.
- 3.6. Домократ ашиглахын өмнө үзлэг шалгалтыг заавал хийнэ. Ингэхдээ дараах зүйлсийг анхаарч шалга.
- 3.6.1. Гидро өргүүрийн шингэний түвшин
- 3.6.2. Өргөх хүчлүүрийн гол хэвийг сунгаж байгаа эсэх
- 3.6.3. Домикратын суурь

### **Дөрөв. Хориглох зүйлс**

- a. Нарядын бус ажил хийх
- b. Нарядын өгсөн ажлын даалгаврыг ямар нөөцөөр, хэзээ, ямар аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллах зэргийг бүрэн ойлгохгүйгээр ажлаа эхлүүлэх
- c. Нэг бүрийн болон хамгаалах хэрэгсэлгүй болон хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглээгүй үед ажилд гарах
- d. Тээврийн хэрэгслийн зогсоолын тормоз болон хурдны хайрцгийн арын дамжуулалтад залгаагүй үед ажлыг эхлүүлэх
- e. Зөөлөн газрын хөрс, зөөлөн гадаргуу өргөх үед зориулалтын хавтан ашиглаагүй өргөх

- f. Хамгаалалтын нэмэлт тулгуур ашиглахгүй ажил гүйцэтгэх
- g. Зориулалтын бус тулгуур, эвүүр ашиглах

### **Тав. Хариуцлага**

- a. Энэ зааврын заалтыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.